Монголчууд оросуудаас 1911 болон 1921 онд тусгаар тогтнолын үйл хэрэгтээ тусламж авсан. Үүний хариу нь Монголд хэрхэн туссан асуудал мөн энэ илтгэлд хөндөгдөх бөгөөд чухамдаа Монголын талаарх Оросын бодлого монголчуудыг Япон руу хандахад хүргэсэн юм.

Япон улсаас тусламж хүссэн удаа дараагийн оролдлого тухай бүртээ ямар асуудлуудыг хөндөж байсан хийгээд Японы байр суурийн асуудлыг дэлгэн тавих ялдамд тухайн үед Монгол улсын статусыг дэлхий дахинаа хэрхэн үзэж байсныг Япон улсын байр сууриар дамжиулан түүхэн бодит байдлын асуудлыг уг илтгэлд хөндөн гаргаж өгнө. Тухайн үед Монгол нь Дорно зүгт Япон руу, Өрнө зүгт Америктэй холбоо тогтоохыг хүсч, оролдож байсан нь Монгол улсын гадаад харилцааны түүхийн зангилаа асуудлуудыг нэг учир энэ удаад Япон руу хэрхэн хандсан, тэр хандалтын шалтгаан нь юу байсан, хэрэг явдал хэрхэн өрнөсөн зэрэг асуудлыг дэлгэн тавих амуй.

ДОНРОВ ГҮН ХИЙГЭЭД ТҮҮНИЙ ЗОРИГ ЗОРИЛТ

Б.ОЮУНДАЛАЙ

ӨМӨЗО-ны Шулуун Хөх хошуу

1911 онд хүрээнд Жамзандамба хутагтыг Богд хаан өргөмжилж Монгол тусгаар улс болсноо нийтэлсний дараа, Богд Хааны Засгийн Газраас Өвөр Монголын эл хошуудад уриалан дагуулах бичиг илгээсэн байна. Цахар шулуун хөх хошуу нь 1912 оны 3 сард Егүзэр хутагт Галсандашаар дамжуулан Богд Хааны Засгийн Газарт бичиг өргөж “Богд эзэн гэгээнээ хаан өргөмжилж тусгаар улс болсныг сонсч баярлан нийлсүгэй” гэх санаагаа нэвтрүүлсэн байна. Дэмий удалгүй тус хошууны Шинэ өөлд сумны занги Донровоос Егүзэр хутагтад сумын тэмдэгтэй бичиг гурван удаа илгээж, тухайн үеийн Цахар монголчуудын “Иргэн лүгээ зах нийлсэн түгшүүртэй хэрэг” ба дөнгөж саяхан байгуулагдсан Иргэн улсын байдлыг тусган, өөрийн зориг зорилтоо илэрхийлсэн байна. Егүзэр хутагтын ахин дахин уламжлан айлтгасны эцэст Богд Хаан улаан бийрээр зарлаг цохож “Занги Донровт дэд зэрэг жинс, занги Лигдэнрашид дэд зэрэг жинс, орлон хөөгч Нацагдоржид гутгаар зэрэг жинс, арваны дарга Цэрэнзавт гутгаар зэрэг жинс тус тус шагнагтун” гэжээ. Орон нутгийн түүхэн материал болон зарим архивын баримтаас үзвэл Донров 1913 онд Богд хааны цэрэгтэй хамтаар Иргэн улсын “Хар цэрэг”-тэй байлдаж гавьяа байгуулсан бөгөөд тус жилийн эцэс буюу 1914 оны эхэнд өөрийн захирсан 400 цэргээ дагуулан Монголд хүрч Богд хааны соёлд дагаж, “Зарлигаар нийслэл хүрэн дэхь Цахар аймгийн цэргийг захирах дарга”-ын тушаалтай бөгөөд “Түшээ гүн” цолтой байв.

Тэрээр манж монгол бичиг мэддэг, үндэстэн ястныхаа гэгээрэл мандлын тулд санааширдаг, цаг төрийн байдлыг сайн ойлгох бөгөөд тодорхой улс төрийн зорилготой хүн байсан байдалтай. Хүрээнд байхдаа Өвөр Монголын эл хошуудаас Богд Хааны засгийг дагах зорилт бүхий хүмүүстэй байнга харьцаж байсан Бавуужавын байдлыг анхаарч, улсын хуралд бичиг барьж Бавуужавын захидалд хариу өгөхийг хүсэн гуйж байжээ. Донров улсын хуралд гуйдал буюу ятгалгын бичиг өргөн Цахар аймгийн ерөнхийлөн захирах сайд Хүүшир мэргэн хамба хутагтын алагдсан ба хязгаарыг хамгаалахын чухал тулгам байдлыг шинжин тайлбарлаж “Богд эзний аврал ачийг умдгайлан улс төрийн сүрийг бууруулах” 6-н зүйлийг тодорхой дурдсан байна.

Гурван улсын хэлэлцээрийн дараа, тэрээр цэргээ дагуулан Егүзэр хутагтад шавь болж үлдэхээр чармайж үзсэн ч бүтсэнгүй, Замын Үүд орчим хэсэг хоргодож байжээ. Иргэн Улсын Засгийн Газраас Донров нарт уучлал хүтээж, тусгай хүн томилон тосч ирсэн байна. Нутагтаа буцсанаас хойш Гогстойн Сүмд сургууль байгуулан сурагч элсүүлж монгол бичиг заав. “Донров гүн хийгээд түүний зориг зорилт” гэх өгүүлэлд Донровын “Үхэрийн жилийн үймээн”-д оролцсон, Богд Хааны засагт дагсан, нутагтаа буцаж сургууль эрхэлсэн өнгөрөлтийг голчлон бичих болно. Донров гүн нь Монголын тусгаар тогтнолын анхны үеийн зүтгэлтнүүдийн нэг байж, тусгаар тогтнолын ажиллагаанд оролцсон түүхт хүмүүстэй нягт харьцаатай байсан бөгөөд улсын дээд доод хуралд ахин дахин бичиг өргөж байсан болохоор Донровын түүхэн материал нь ч ХХ зууны эхний Монголын түүхэнд холбогдох зарим асуудлыг баримттай тусгаж болно. Мөн Шанд Адуучны Жамсранжав, Хишигтэн хошууны Баянцагаан, Шулуун хөх хошууны Лигдэнраш зэрэг олон түүхэн хүмүүсийн үйл мөрийг тодруулахад хажуугийн сүвэгч хангах байх аа.

THE ESTABLISHMENT OF THE PROVINCE OF MODERN INNER MONGOLIA AND THE BANNER AND LEAGUE SYSTEM

HIROKAWA Saho
Niigata University, Japan

During the Qing Dynasty, Mongolian society was under the banner and league system in which Mongolian hereditary *Wanggong* (王公: a Manchu title meaning “prince”) governed people in each banner. In Mongolian nomadic society, Wanggong dominated people in the banner not by the principle of territorial jurisdiction, but based on individualistic governance. The league (*Chuulgan, Ayimag* in Mongolian) was an association of banners, and there was no actual organization. In the territory of the Qing Dynasty, six leagues were organized in Inner Mongolia and four leagues in Outer (*Khalkha*) Mongolia. The banner heads, known as *Jasag*, held a league conference and discussed matters relating to the banners. The Qing Dynasty elected the head of the league from these *Jasag*. Until the modern era, Mongolian people basically did not own their land and lived a nomadic life.

In those days, according to the *fengjin* (closure) policy, *Hanren* (漢人, Han Chinese) could not migrate to Northeast China and Mongolia. However, in the beginning of the 20th century, Han Chinese peasants began migrating to Inner Mongolia because of population increase and natural disasters in the Chinese mainland. Consequently, traditional nomadic society in southern Inner Mongolia gradually evolved into an agrarian society. As Han Chinese peasants cultivated banner land and their population increased to some extent, the *Xian* (縣: Chinese administrative organization) was established there. The banners governed the *Xian* area, too, so that the dual system of banner and *Xian* existed in the same area. Furthermore, the province (省: Chinese local government) bordering Inner Mongolia sought to strengthen its influence on the *Xian* areas, leading to the weakening of the banner and league system in the early 20th century.

In 1914, after the Xinhai Revolution, the government of the Republic of China established three special districts--Ike Juu, Josut and Chaqar--in league areas of Inner Mongolia. When the revolution occurred in Khalkha Mongolia in 1921, the influence of the Soviet Union there was strengthened. This led the Beijing government to plan to recover Khalkha Mongolia and establish a province. In 1924, Beijing held the Mongolian conference, at which the Wanggong of Inner Mongolia argued for retaining and enhancing the banner and league system. After the establishment of the nationalist government (Kuomintang) in 1928, the Chinese authorities eventually changed the three special districts into a province. Under these circumstances, the banner and league system and feudal Wanggon system barely survived. As the sense of crisis among Mongolian Wanggon and intellectuals deepened, they organized a delegation from Inner Mongolia and protested against the policy of the nationalist government. However, when the Imperial Japanese Army invaded Eastern Inner Mongolia and established the Manchukuo government in the 1930s, the army abolished the Mongolian traditional leagues and feudalistic class system. In this research, I consider the transition of the banner and league system by examining the establishment of provinces in Inner Mongolia and the response of Mongolian aristocracy in the 1920s.

STUDY ON THE HISTORY OF MONGOLIAN STUDYING ABROAD IN JAPAN IN THE FIRST HALF OF THE 20TH CENTURY

NAHEYA

Department of Mongolian History, Inner Mongolia University

Chinese people studying abroad began in the late Qing Dynasty and formed scale in the middle of the 20th century. Among that, there are a lot of scholars who go to neighboring Japan, hence the influence is quite large. Therefore, the relevant research in this academic circle is also quite rich. At present, the study of history of Chinese people studying in Japan mainly presents three trends: First, the study of this issue from the perspective of political history, such as the relationship between the students studying in Japan and the establishment of Tongmenghui, and the relation with the 1911 Revolution. Second, the study of the history of Sino-Japanese cultural exchanges, such as the study of Western culture through Chinese students studying in Japan, etc.; the third is the study of overseas study policies during the late Qing Dynasty and the Republic of China. However, the research on the study of students from the minority region to study in Japan has not been fully developed, and this is a topic worthy of further study.

In the first half of the 20th century, a large number of Inner Mongolians went to study abroad. Among them, Mongolian students tend to study in Japan. Although this is a topic worthy of in-depth study, the relevant works are rare. However, there are a lot of studies of Inner Mongolia's modern and contemporary educational culture history, which is closely related to the study of history of Inner Mongolians studying in Japan. It can be summarized as following three aspects:

(1) The research in mainland China and Taiwan mainly focuses on the history of education development, and conducts a detailed investigation on the national education system in each period.

(2) Japan's study of modern Chinese history is mainly based on Han students and the investigation is basically not related to the field of Chinese minority students studying in Japan. In addition, Japan's research on the history of modern Inner Mongolia education mainly focuses on political and social history and policy history, but it does not specifically discuss the issue of studying abroad;

(3) Other related research, such as Li·Narangoa's «Japan's Religious Policy for Mongolia: 1932-1945» (Japanische Religionspolitik in der Mongolei 1932-1945: Reformsbestrebungen und Dialog zwischen japanischem und mongolischem Buddhismus, Wiesbaden: Harrassowitz Verlag, 1998) is based on the example of Inner Mongolian monks studying in Japan and made a further investigation on the issue of religious management and Japanese pseudo-infiltration in Inner Mongolia in the 1930s and 1940s. However, it also did not cover the topic of Inner Mongolians studying in Japan.

The above-mentioned domestic and foreign researches provide a lot of useful clues and related materials for this topic, but, still, there is very little content directly related to this topic. From the current point of view, this topic still belongs to the “unknown” field in academic research. In modern times, the dispatch of Inner Mongolian students abroad started earlier. For example, the Muslims in Xinjiang in the late Qing Dynasty and the Tibetans in the Kangqu, Tibet had the first modern school in 1907, but Inner Mongolia began to send Mongolian students overseas in 1906. In modern Chinese minority education, Inner Mongolian students have a large number of students studying in Japan, and they also have the widest range of majors, including agriculture, forestry, livestock, veterinary, electrical, industrial, civil engineering, horticulture, medicine, military, aviation, education, home economics, business and other fields. After they returned to China, they played an important role in the construction of Inner Mongolia and the establishment of the Inner Mongolia Autonomous Region. This is a very representative example of both the study of the history of Chinese ethnic minorities and the entire process of the Chinese nation’s rejuvenation.

History has proved that after return to China, most Mongolian young intellectuals studied in Japan have devoted themselves to the construction of Inner Mongolia Autonomous Government, Inner Mongolia Autonomous Region and People’s Republic of China, and have made an indelible contribution to the modernization of Inner Mongolia in the fields of culture, education, politics, economy and military.

ОРЧИН ЦАГИЙН МОНГОЛ УЛСЫН ТҮҮХ БИЧЛЭГИЙН ТУХАЙ ХЭДЭН АСУУДАЛ: ТҮҮХИЙН ЗОХИОЛООР ТӨВЛӨХ НЬ

ЛЮ ДИНАНЬ

Бээжин Их Сургуулийн Гадаад хэлний дээд сургууль

Түлхүүр үгс: Монгол улс, Түүх бичлэг, Түүхийн хөгжил, Нөлөөлөлцөх харилцаа

1921 онд ардын хувьсгал ялснаар монгол улс тусгаар тогтнолоо байгуулсан. 1934 онд төр засаг байгуулагдсаны 13 жилийн ой бөгөөд анхны Үндсэн хууль батгагдсан 10 жилийн ойг тохиолдуулан А. Амарын “Монголын товч түүх”, Л. Дэндэвийн “Монголын товч түүх” болон Чойбалсан зэргийн “Монгол ардын үндэсний хувьсгал анх үүсэж байгуулагдсан товч түүх” гэдэг гурван ботийг хэвлэн гаргасан билээ. 1954 онд “БНМАУ-ын түүх” (нэг боть) хэвлэн гарсан юм.

XX зууны 60-аад оны дунд үеэр, “БНМАУ-ын түүх” (гурван боть) хэвлэгдсэн юм. 1995 онд “20-р зууны Монгол түүхийн тойм”-ыг гаргасан бол 2003 онд “Монгол улсын түүх” (таван боть) хэвлэн гаргасан билээ. Дээр дурдсан түүхийн зохиолоор төвлөн орчин цагийн Монгол улсын түүх бичлэгийн хөгжлийн замналыг сайн тодорхой харж болно. Орчин цагийн Монгол улсын түүх бичлэг нь тодорхой цаг хугацааны онцлогтой байна. Тухайлбал Монгол улсын нийгэм түүхийн хөгжлийн байдлыг дагаж түүхэн үг хэлээр хуучин нэг цаг үеийн төгсгөл, шинэ нэг үеийн эхлэлийг тунхагласан байна. Мөн түүнчлэн Монгол улсын хөгжилд үзэл суртлын талаар түүхэн тайлбар хангаж үзэл санааны чухал түшиг тулгуур болдог. Нэг талаар Орчин цагийн Монгол улсын түүх бичлэг бодитой нөхцөлд төрөн гарсан бол нөгөө талд нь нийгмийн хөгжлийн бодитой байдлаас болсон шаардлагыг хангаж чухал асуултуудыг түүхэн бичлэгийн хэлбэрээр хариулж өгдөг. Иймд түүх бичлэг болон түүхийн хөгжлийн хооронд тодорхой нөлөөлөлцөх харилцаа тогтсон юм.

СОЁЛ ИРГЭНШИЛТ ЧАНАРЫН СТАНДАРТУУДЫН ҮҮДНЭЭС ЭРДЭНЭПЭЛ ЛАМЫН МОНГОЛЫН ТҮҮХИЙГ АВЧ ҮЗЭХ НЬ

ЖЕЛЕЗНЯКОВ А.С.

ОХУ, Москва хот

Саяхан Монгол Улсад монголын түүхч лам Н.Эрдэнэпэлийн (1887-1960)¹ мэндэлсний 130 жилийн ойг тэмдэглэжээ. 1930 оны сүүлчээр түүний бичсэн “Монгол дахь шашинуудын эцсийн шалтгаан”² гэдэг бүтээл тэр үеийн монголын түүхийн талаарх бүтээлүүдийн дотор онцгой байр эзэлдэг. Монголын нүүдэлчдийн дотроос төрсөн эрдэмтний үнэхээр өвөрмөц ховор энэ бүтээл нэг талаас түүний өмнөх үеийнхний буюу XVII, XVIII болон XIX зууны түүхч лам нарын шинжлэх ухааны дэг сургуулийн баялаг туршлага дээр, нөгөө талаас XX зууны эхний хагасын бодит байдлыг өөрийн нүдээр харж ажиглаж байсан түүхчийн хувийн туршлага дээр тулгуурлажээ.

Н.Эрдэнэпэлийн бүтээл бүр XVIII, XIX зуунд европын эрдэмтдийн тогтоосон өнөө үед тун амь бөхтэй оршин буй соёл иргэншилт чанарын стандартуудын тухай төсөөллүүдийг олон талаар үндсээр нь эргүүлсэн юм. Эдгээр стандарт нь цорын ганц тоон дээр буй соёл иргэншил гэдэг ерөнхий ойлголтоор бол дэлхий ертөнц соёл иргэншилт болон зэрлэг бүдүүлэг (буюу соёл иргэншилгүй) гэсэн хоёр хэсэгт хуваагдаж байна. XIX зууны сүүлчээр XX зууны эхээр болон дунд үеэс түүхийн философчид хүн төрөлхтнийг хуваасан иймэрхүү ёозгүй муухай хуваалтаас зугуухан татгалзаж эхэлсэн. Хүн төрөлхтнийг соёл иргэншлүүдийн олонлог хэмээн төсөөлөх болсон соёл иргэншлийн хандлага үүссэн тэр олонлогт “энэ үгийн хуучин утгаар” өөрөөр хэлбэл цорын ганц тоон дээр хэрэглэж буй “соёл иргэншил” гэдэг ерөнхий ойлголтын үүднээс “нэлээд соёлгүй”³, локаль соёл иргэншил орж болно.

Гэвч төр улсын, бичиг соёлын, шашины хоёр мянга гаруй жилийн түүхтэй Монгол Улс локаль соёл иргэншлүүдийн нэрсийн сонгодог жагсаалтын нэгэнд нь ч өртөөгүй байна. Соёл иргэншлийн сонгодог схемүүдэд Монголд төвтэй Өвөр Азийг локаль соёл иргэншлүүдийг хамарсан хүй нэгдлийн (өөрөөр хэлбэл, зэрдлэг бүдүүлэг) зах хязгаар нутаг маягаар харуулжээ. Нэг тохиолдолд түүнийг “зэрлэг бүдүүлгийн буюу нүүдлийн төлөв байдлаасаа”⁴

¹ Гандантэгчэнлин хийдийн Хамба лам, Чин бишрэлт гавж Н. Эрдэнэпэл (Гандантэгчэнлин хийдийн Хамба лам, Чин бишрэлт гавж Н. Эрдэнэпэлийн 130 жилийн ойд зориулав). Улаанбаатар, 2018.

² Эрдэнипэл. Конечная причина религий в Монголии / История в трудах ученых лам (сост., ред. А.С.Железняков, А.Д.Цендина). М., Товарищество научных изданий КМК, 2005.

³ Хантингтон С. Столкновение цивилизаций. М.: ООО «Издательство АСТ», 2003, с.47.

⁴ Данилевский Н.Я. Россия и Европа. Взгляд на культурные и политические отношения славянского мира к германо-романскому. М.: Эксмо, 2003, с. 97.

гараагүй зах хязгаар нутаг, нөгөө тохиолдолд соёлын үл оршихуйд аль хэдийнээ явж одсон⁵ буюу хөшиж царцсан нүүдлийн соёл иргэншлийн хэлтэрхий⁶ болгон харуулжээ.

Соёл иргэншлийн онолын сонгодогуудын энэхүү басамжилсан хандлага Монголын тухай тэнд хот суурин байхгүй, хүмүүс нь нүүдэлчдийн бүдүүлэг амьдралтай, бичиг соёлын түүхгүй тийм газар мэт төсөөллөөр нь өдөөгджээ. Одоо хүртэл нүүдэлчдийн аж төрдөг газар нутаг хөрш зэргэлдээх газар тариалангийн нийгмүүдийн “маргаантай зах хязгаар шахуу газраас” цааш гарахгүй байгаа гэж нэр хүндтэй зохиогчдын эрэгцүүлэл дуулдсаар л байна⁷. Н.Эрдэнэпэлийн бүтээл хуучны энэ хоцрогдсон хэв маягийн сэтгэлгээг бүрэн няцааж, монголын түүхийг улс төрийн болон социальны үйл явдлуудаар, ордны болон сүм хийдийн эргэлтүүдийн будлиануудаар дүүрэн, хотын амьдралын болон баялаг бичгийн соёлын, худалдааны болон гар урлалын түүхтэй улс гэдгээр харуулж байна. Нүүдэлч малчдын аж төрдөг тал нутгийн нөхцөлд хот нь ердөө нүүдлийн эзэнт гүрний нийслэл, хааны өртөөтэй, үй олон гэрүүд хүрээлэгдсэн, сүм хийдтэй, тэр ч байтугай хэдэн арван үхэр тэрэг хөлөлсөн асар том орон зайд гэр өртөөнүүд ярайсан тал нутгаар хөдөлж нүүсэн том хот байсан юм.

Н.Эрдэнэпэлийн бүтээл эдүгээ цагт Өвөр Азийн түүхтэй салшгүй холбоотой, Евро Азийн төвд оршигч Оросын болон Хятадын агуу орон зайд гүнзгий шаантаглан орсон энэ бүс нутгийн төв болох Монголын түүхийг шинээр харах, шинэ үзэлийг боловсруулахад эрдэмтэн судлаачдад тус болох нь эргэлзээгүй. Энэ бүс нутагт оршин амьдардаг бие биенээсээ салгахын аргагүй ард түмнүүдийн хувьд түүх нь нийтлэг байдаг төдийгүй, мөн тэдний соёл уламжлал шашны суурь нь нийтлэг нэг байдаг бөгөөд эдгээр нь бие биетэйгээ салшгүй холбоотой билээ.

Улаанбаатар бол Өвөр Азийн бүрэлдэхүүнд бүхэлдээ багтдаг цорын ганц бүрэн эрхт тусгаар улсын нийслэл мөн бөгөөд дэлхийн улс төрийн байгууламж олон туйлт болж байгаа орчин үеийн газрын зурагт энэ бүс нутгийг бие даасан туйлын хувиар төлөөлж байна. Тэгснээр Монгол Улс нь түүний ойрын болон холын соёл иргэншлийн хүрээлэлтэй тоолж барахын аргагүй хэлхээ холбоогоороо гүн гүнзгий сүлжилдсэн тусгаар, локаль соёл иргэншлийн төв болон товойн тодорч байна.

⁵ Шпенглер О. Закат Европы. Очерки морфологии мировой истории. 1: Гештальт и действительность / Пер. с нем., вступ. ст. и примеч. К.А. Свасьяна. М.: Мысль, 1993, с. 163.

⁶ Тойнби А.Дж. Постигание истории. Сборник / Пер. с англ. М.: Прогресс, 1991, с. 181.

⁷ Холл Т. Монголы в мир-системной истории. / Монгольская империя и кочевой мир. Улан-Удэ: Изд-во БНЦ СО РАН, 2004, с. 158.

THE SOVIET UNION'S INTELLIGENCE WORK IN INNER MONGOLIA AFTER WORLD WAR II

HUSEL Borjigin
Showa Women's University, Japan

Keywords: Soviet Union, Intelligence Work, Inner Mongolia, After World War II

After the founding of the Soviet Union, its policy regarding Mongolia was vital to the future of both Inner and Outer Mongolia. Based upon documentation from the Russian State Archive of Socio-Political History, the Foreign Policy Archive of the Russian Federation, and the National Archive of Mongolia, this paper investigates the Soviet Union's intelligence work in Inner Mongolia after World War II. The main assertions are that 1) After it stationed military forces in northern and north-eastern China in August 1945, the Soviet Union collected intelligence mainly through both Soviet and Mongolian intelligence agents. After its withdrawal from China, the Soviet Union's Consulate in Manchuria collected intelligence while Mongolia offered the Soviets intelligence about Inner Mongolia. 2) The Soviet Union used Inner Mongolia in its foreign relations with China and Mongolia. 3) Both China and Mongolia accepted the Soviet Union's stand on the future of Inner Mongolia.

20TH CENTURY; INDO–MONGOLIAN RELATIONS

Maqsooda. S. Sarfi
Kokuritsu Komatsu University, Japan

Keywords: Mongolia, Buddhism, Kashmir, India, Diplomatic relation

As we go through the pages of history there is a tremendous evidence that Mongolia from its inception has its ties with other peoples of the world. As for India, the Indo-Mongolian spiritual and cultural bond goes back to very ancient times. The Kashmiri Buddhist monks and scholars undertook long arduous journey through the silk route to the steppes and then to eastward to China and Mongolia to spread the preaching of Buddha. India, the spiritual neighbour of Mongolia, has strong influence on Mongolian every walk of life religiously as well as culturally.

On the political front, India was among the so-called non-Socialist countries to recognize and establish diplomatic relations with the then Mongolian People's Republic on 25th December 1955. Mongolia opened its embassy in New-Delhi in 1956 and India in Mongolia in 1971. India also strongly supported that Mongolia be accepted a member state of the United Nations. Since then the bilateral political relations have been growing and developing. Bilateral high-level visits have become frequent, with Mongolian Prime Ministers, President, Parliament speakers visiting India and with Indian President, Vice- President, Lok Sabha speaker and prime Minister paying official and state visits to Mongolia. An important factor is the Mongolia considers India as its Third world Neighbor and India is proud to be one.

India and Mongolia, the two spiritual neighbors, were and are unanimous that they should now aim to bridge their geographic divide via technology and new means of connectivity. Also the two countries agree that both of them can do a lot in terms of promoting regional connectivity for growth and development, especially in Asia, promoting peace and prosperity in the Indo-Pacific region. India is emerging an economic power and also a military power in Asia. But standing at a long distance from Mongolia in physical terms, this friendship has to be based on cultural affinity and values which fortunately are there to become the basis of relationship.

In this paper the author will throw the light on how the two countries jointly has affirmed friendship and cooperation through these 60 years since they diplomatically got connected to each other. How both the countries worked for the development in the diplomatic, economic, cultural and defence fields and continuously are pledging to maintain peace in the region.

ТУВА ДАХЬ МОНГОЛ СУДЛАЛЫН ТҮҮХЭН ЗАМНАЛ БА ӨНӨӨГИЙН ЗАРИМ ТУЛГАМДСАН АСУУДЛУУД

Б.БАЯРСАЙХАН⁸

Монгол судлал нь Монгол улсаас гадна БНХАУ, ОХУ, Япон, Герман, Венгр, АНУ, Франц, Чех, Польш зэрэг орнуудад, сүүлийн жилүүдэд Өмнөд Солонгос, Энэтхэг, Турк, Канад зэрэг гадаадын олон орнуудад идэвхтэй хөгжиж, дэлхийн шинжлэх ухааны тавцанд өөрийн байр сууриа нэр хүндтэй эзэлж байна. Евразийн Түрэг-Монголын ард түмний түүх, гарал үүсэл, угсаатны зүй, ахуй соёл, Евразийн онол, түүний орчин үеийн үзэл санаа монголч эрдэмтэдийн сонирхлыг өдрөөс өдөрт улам ихээхэн татсаар байгаа билээ.

Тува судлал нь Өмнөд Сибирийн түрэг судлалын нэгээхэн хэсэг бөгөөд нөгөө талаар Төв Азийн судалгаа, тодорхойлбол монгол, төвд судлалтай салшгүй нягт холбоотой байдаг. Тувачууд нь түүхийн олон зуун жилийн туршид монголчуудтай нэгэн том гүрний бүрэлдэхүүнд багтан, нэгэн шашны дор, хөрш зэргэлдээ өнөөг хүртэл амьдарч ирсэн баялаг түүхтэй ард түмэн билээ. Тувачуудын гарал үүсэл, уламжлалт ахуй соёл нь монгол ард түмний соёл, амьдралын хэв маягтай салшгүй нягт холбоотой ирсэнийг түүхэн баримт, эх сурвалж тодоор гэрчилдэг бөлгөө.

Тува дахь монгол судлалын анхны эрэл, судалгааны шатыг өнгөрсөн зууны 1970-1990 онуудын зааг хэмээн тодорхойлж болно. Энэхүү шатанд хуучин монгол бичгээр бичигдсэн түүхэн баримт, эх сурвалж, монгол зохиолчдын бүтээлүүдийг орос, тува хэл рүү хөрвүүлэх ажил эрчимтэй явагдаж иржээ.

Тувагийн нэрт түүх судлаач Ю.Л. Аранчын Тувад монгол судлалын цаашдын хөгжлийн судалгааны үндэс суурийг тавихад онцгой үүргийг гүйцэтгэсэн байна. Тэрээр ирээдүйн монгол судлалын мэргэжилтэнүүдийг Монгол улс болон ЗХУ-д бэлдэх төрийн бодлогыг боловсруулан, түүний санаачлага болон дэмжлэгээр Тува улсын Төв архив, Үндэсний музейн болон Тувагийн Хэл, уран зохиол, түүхийн судалгааны хүрээлэнгийн гар бичмэлийн санд хадгалагдаж буй эх сурвалж, түүхэн баримтуудын гарчиг, цэсийн жагсаалтыг бүрдүүлэх, системчлэх, монгол, төвд хэлнээс тува, орос хэл рүү орчуулах ажлын бүлэг байгуулж, энэхүү ажилд монгол хэлний мэдлэг бүхий хүмүүсийг, лам хуврагуудыг хамруулан бүхий боломжийг ашиглан, үйл хэрэгч болгосон байна. Энэ нь тува, монгол судалгааны цаашдын эргэлтэнд оруулахад, монгол судлалын эхлэлийг тавьсан хэмээн тэмдэглэж болох байна.

⁸ ОХУ-ын БНТува улсын Хүмүүнлэгийн болон хэрэглээний нийгэм, эдийн засгийн судалгааны хүрээлэнгийн тува, монгол судлалын секторын ЭША, Ph.D.

Тувад монгол судлалыг албан ёсоор үүсгэн байгуулах, хөгжүүлэх, гүнзгийрүүлэн судлах нь Тувагийн ШУ-д тулгамдсан чухал асуудлуудын нэг болсоор ирсэн билээ. Тэрээр 2010 оны 12 сарын 1-нд Тувагийн Хүмүүнлэгийн судалгааны хүрээлэнгийн захирал (2008-2012), монголч эрдэмтэн, академч, профессор К.А. Бичелдейн санаачилгаар тус хүрээлэнгийн дэргэд Монгол судлалын төвийг нээн, монгол судлалын секторыг байгуулсан нь тува судлалын хамрах хүрээг улам өргөтгөх үндэс суурийг тавьсан юм.

2010 оноос эхлэн Монгол улсын ШУА-ийн Түүх, Археологи, Хэл, уран зохиолын хүрээлэнгүүдтэй, Монгол уламжлал академи, Баян-Өлгий аймаг дах Нийгэм эдийн засгийн судалгааны төв, Ховд Их сургууль, “Тод номын гэрэл төв”, Хөх хотын Монгол судлалын сургууль зэрэг байгууллагуудтай хамтын ажиллагааны хэлэлцээр байгуулсаны улмаар түүний хүрээнд монгол, тува ард түмний ахуй соёл, түүх, хэл, аман зохиол, соёлын харилцааг улам гүнзгийрүүлэн судлах, хамтын томоохон ном бүтээл хэвлэн гаргах, эрдэм шинжилгээний хурлууд зохион байгуулах, хамтарсан хээрийн судалгаа явуулах зэргээр үр бүтээлтэй ажиллаж байна.

Өнөөгийн байдлаар Тува дах монгол судлал нь зөвхөн анхан шатны хөгжлийн шатанд байгаа боловч цаашид ОХУ болон Монгол улсын ШУ-ны бүхий салбаруудын хүрээнд хамтран ажиллах үндсэн суурь, тулгуур эх хэрэглэгдэхүүний нөөц хангалттай байгаа боловч цаашид Тувад монгол судлалыг улам үр бүтээлтэй хөгжүүлэхэд хамгийн гол тулгамдсан асуудлуудын нэг бол дундад зууны түүх, уран зохиол, монгол судлалаар дагнан ажиллах хэлний зохих мэдлэг бүхий залуу судлаачдын хүч дутагдаж байгааг дурдах нь зүйтэй байна. Мөн түүнчлэн Тувад монгол судлалыг хөгжүүлэх төрийн бодлого гарган анхаарал хандуулах, Олон улсын монгол судлалын холбооны зүгээс бодит тусалцаа дэмжлэг авах зайлшгүй шаардлагатай байна.

A TRACE OF FORMATIONS OF NATIONAL IDENTITY AMONG INNER MONGOLS IN 20TH CENTURY

NASANBAYAR
Inner Mongolia University

Chinese pioneering anthropologist Fei Xiaotong pointed out in 1980s that Chinese nation as a self-conscious national entity, has emerged in the confrontation between China and western powers over the past century, but as an unrestrained national entity, was formed through thousands of historical processes». How have national minorities as members of the self-conscious national entity join the political body and contributed to construction of the Chinese national identity. Since the beginning of the 20th century, the Inner Mongols has gone through a historical process that is not plain sailing, forming today's national identity (Chinese national identity) and ethnic Mongolian identity. This article, based on historical facts relevant to subject in question in Inner Mongolia, draws the outline historical formation of the Mongolian identities as a member of the Chinese nation and puts forward some arguments, such as a prosperous and peaceful the situation of the state is a key to the crucial factors for ethnic groups to form and keep on a firm, and correct national identity and ethnic identity.

МОНГОЛ ХЭЛ БИЧИГ ДАЙЧИН ГҮРНИЙ ЭХЭН, ДУНД ҮЕИЙН ТӨВДӨД

Боржигидай ОЮУНБИЛИГ
Дундад Улсын Рэнь Минь Их Сургууль

13-14 дүгээр зуунуудад Монголын Эзэнт Гүрэн Евроазийн түүхэнд агуу их нөлөө гаргасан. Түүнээс сүүлээрх хэд хэдэн зуунуудаар ч гэсэн Монголын нөлөө багасч очсон боловч харийн монгол элемент ба нөлөө нь энэхүү орон бүсийн улс төр ба соёлын хүрээнд ер нь хүчтэй үйлчилсээр ирсэн юм. Тийнхүү монгол судлал нь монголын цаг үеэс сүүлээрх Евроазийн судлалд чухал байр эзэлсээр бий.

17-18 дугаар зуунуудаар Төвд, Уйгур, Хасаг, Буриад зэргийн Монголоос бусад дотоод азийн үндэстэн ба орнуудад монгол хэл бичиг мөнхүү чухал роль гүйцэтгэж байв. Түүний дотор, Монгол-Юан Улсаас нааш, ялангуяа Төвдийн бурханы шашин Монголд хоёр дахь удаагаа дэлгэрснээс сүүлээр ба Хошууд Хаалиг Төвдийг 75 жил ноёлсноос хойш, монгол элементууд Төвдийн улс төр ба нийгмийн амьдралд ер нь чухал үүрэг гүйцэтгэж байжээ. Тус өгүүлэлд Дайчин Гүрний Тайзун, Шизу, Шэнзу гурван хааны үеийн зарим монгол бичиг баримтууд ба Найралт Төв, Тэнгэрийн Тэтгэсэний үеийн Зарлигаар Зарсан Төвдөд Суух Сайдад холбогдох албан бичгүүдэд тулгуурлан 17-18 дугаар зуунуудаар монгол хэл бичиг Төвдөд ямаршуу түүхэн байр суурь ба үүрэгтэй байсан талаар өгүүлэх болно.

Энэхүү өгүүлэлд бас Төвдийн архивт хадгаалагдаж байгаа Дайчин Гүрний Зарлигаар Зарсан Төвдөд Суух Сайдад холбогдох албан бичгийн талаар анх удаа танилцуулах болно.

НЭГЭН КОММУНИСТ ӨВӨР МОНГОЛ ЗАЛУУ: ХУВЬ ТАВИЛАН, ӨВ

С.ЧУЛУУН

Монгол улс. Шинжлэх Ухааны Академи

XX зууны эхэн хагасын монголын түүхэнд монгол туургатны оролцоо, тэдний улс төр, соёл, шинжлэх ухааны үйл ажиллагааны тухай судалгаа өнөөг хүртэл гадаад, дотоодын эрдэмтдийн судалгааг татсаар байна. Монгол улсын тусгаар тогтнолын асуудлаас гадна нийгэм соёлын харилцаанд Өвөр Монгол, Буриад, Барга зэрэг газрын монголчууд ихээхэн идэвхтэй оролцох болсон. Тэдний дундаас нэгэн өвөр монгол залуугийн тухай судалгаа өнөөг хүртэл огт орхигдсон байна. Түүний нэр Өлзийбадрах гэнэ. 1920-иод оны үед Монгол улсад Бээжингээс хувьсгалын хэргээр монгол улсад ирсэн бөгөөд улмаар монголын төрөөс Зөвлөлт улсад сургасан анхны сурагч нарын дотор багтаж Ленинград хот (одоогийн Санкт-Петербург хот) -од суралцжээ. Тэрээр хуульч мэргэжлээр анх удаагаа мэргэжлийн диплом авсан бөгөөд удалгүй 1930-аад оноос Монгол улсад ирж ажилласан байна.

Тэрээр Орос эмэгтэй Орлова хэмээхтэй гэрлэж хамт Монгол улсад 1936 он хүртэл амьдарсан бөгөөд монгол улсад 2 жил шоронд хоригдсон тул эхнэр нь буцжээ. Өлзийбадрах монгол улсын шоронгоос гарч дахин Зөвлөлтөд цэрэг-анагаах ухааны сургуульд суралцахаар очсон бөгөөд удалгүй Монгол улсад өрнөсөн хэлмэгдүүлэлт өртөж 1938 онд цаазлагдсан байна. Түүний орос эхнэрийн хадгалж байсан гэрэл зураг, баримт, захидал зэргийг шинээр илрүүлэн олсон бөгөөд Өлзийбадрахд холбогдох бусад баримт материалыг Оросын болон Монголын архивуудаас илрүүлж түүний намтар, Монгол болон орос дахь улс төр, сургалтын үйл ажиллагаа, түүний эхнэрийн хувь тавилангийн тухай сонирхолтой баримтуудыг өгүүлэх болно.

Өлзийбадрах нь XX зууны Монголын түүхийн судалгаанд бараг мартагдсан бөгөөд түүний намтрыг судлах нь тухайн үеийн Монгол улсад ирсэн өвөр монголчуудын түүхийн асуудлыг тодруулахад чухлаас гадна өмнө огт судалгааны эргэлтэд ороогүй учир намтар судлалын түүхэнд чухал ач холбогдолтой юм. Мөн тэдний амьдралын түүхийг харуулсан гэрэл зураг, эд өлгийн зүйлс, архивын болон аман түүхийн мэдээлэл зэрэгт тулгуурлан судалсан бөгөөд түүний эхнэрийн бичсэн Өлзийбадрахын амьдралыг хүүрнэсэн шүлэг, мөн ганц охинтой нь уулзсан уулзалтын мэдээ зэргийн талаар өгүүлнэ.

Өлзийбадрахын түүхийг монголын түүхийн судалгаанд тухайн үед улс төрийн хүрээнд нэлээд идэвхтэй үүрэг гүйцэтгэж байсан Өлзийтийн Бадрахтай андуурч ирсэн түүхийг түүх бичлэгт залруулах нь уг илтгэлийн нэг гол зорилго байсан юм. Дан ганц Өлзийбадрахын намтар, үйл ажиллагаа бус түүнтэй холбоотой тухайн үед болж байсан бусад асуудал, монгол-оросын иргэдийн харилцааны асуудлыг тодруулахад нэмэр болно.

**FROM PROFESSIONAL TO AMATEUR SEARCH
FOR CHINGGIS KHAN'S TOMB: THE CHINESE MUSLIM
YEARNING FOR THE "MONGOL-YUAN CULTURE"**

Uradyn E. BULAG
University of Cambridge

Keywords: Chinggis Khan, Mortuary, Chinese Muslim, "Mongol-Yuan Culture", Professional, Amateur

Chinggis Khan's tomb has never failed to fascinate the minds of modern people, especially archaeologists and historians, due in no small part to the potential prize associated with its discovery. For what may be called "professional" Chinggis Khan fortune hunters (both Mongol and non-Mongol), the Mongol imperial mortuary practice of secret burial and traditional belief of not disturbing the dead are never a deterrence strong enough to stop them. If professional archaeologists involved in Chinggis Khan's tomb searching is too embedded in imperialism, nationalism and politics, then what about amateur endeavours?

This paper documents the recent resurgence of Chinggis Khan's tomb "fortune-hunting" in the Ningxia Hui Autonomous Region, practiced primarily by Chinese Muslim "amateur" scholars. Their proudest accomplishment so far was the alleged discovery of the mortuary of Chinggis Khan's corpse in Haiyuan county featured in a documentary on CCTV aired on the eve of the 60th anniversary of the Autonomous Region (founded on the 22nd of September 1958). Chinggis Khan was historically known to have died in the Liupanshan mountains and to have willed that the news of his death not to be released until the Tangut state was crushed. Where was his corpse kept in the hot summer of 1227 and how long had it been kept before it was transported to his homeland for burial? The search for answers to these and other related questions is important not just to establish Chinggis Khan's mortuary, but also to "*dazao*" (forge) the "Mongol-Yuan Culture" in the depths of the Chinese Muslim community.

**THE DIALECT FEATURES OF MONGOLIAN
IN THE YIBU 譯部 OF THE *LULONGSAI LÜE* 盧龍塞略**

Kereidjin.D.BÜRGÜD
Chinese Academy of Social Sciences

Keywords: *Lulong sai lüe*; *Yibu*; Sino-Mongol glossary; Chinese characters

Lulong sai lüe 盧龍塞略 (‘Outline of the Lulong pass’; henceforth abbreviated as LLSL) is a military records book published in Ming 明 Wanli 萬曆 38 (1610) year. The Sino-Mongol glossary belongs to the *yibu* 譯部 of the LLSL, and it contains more than 1300 Mongolian words. The most striking feature of the glossary that distinguishes the collection of other words is the phenomenon of “multiple translations of one word”. “such as, called 曰”, “one called 一曰”, “called again 又曰”. Here “called 曰” and “called again 又曰” have different levels of meaning. This article mainly aims at “one word multiple translation” entries, for each to carry on the textual research, the causes of the “multiple translations” are summarized. The analysis results shows that “called” and “called again” have three different functions. First, the different spelling of Chinese characters. Second, the different pronunciation of ancient and modern times. The third is the dialect difference of one word. This study compares the term “the dialect difference of one word” with other Sino-Mongol glossary of different eras, and tries to analyze the Mongolian dialect features of the *Yibu* of the LLSL.

ХРИСТИЙН ШАШНЫ ХҮМҮҮСИЙН НАЙРУУЛАН ЗОХИОСОН НЭГЭН СУРАХ БИЧГИЙН ХЭЛ НАЙРУУЛГЫН ТУХАЙ

Тукүсү, КҮРЭБИТО
Токиогийн Гадаад Судлалын Их Сургууль

Түлхүүр үг: Христийн шашин, Цахарын Шанд Адуучин хошуу, Хадан Сөм, сурах бичгийг

XX зууны 20-30-аад оны үед, Европын Христ шашны номлогч нар Монгол оронд ирж, өөрийн шашинаа сурталчлан ухуулахын төлөө уйгагүй ажиллаж байжээ. Тэл монгол соёлд ойртон, монголчуудын сэтгэлийг татахын тулд, элдэв олон арга ухаан эрж хайж байжээ. Христийн номлогч нар монголчуудыг өөрсдийнхөө шашин руу татахын тулд, асар их чармайлт гарган, олон ажил хийж бүтээжээ. Тэдгээр номлогчдын дотроос хамгийн алдартай нь яахын аргагүй Антон Моэстарт байв. Тэр бол 18 жил Ордос нутагт амьдарч, «Ордос толь»-оос эхлэн олон ном бүтээл туурвиж, монгол соёлд гавьяат үйлс бүтээсэн хүн юм.

Христ шашины номлогч нарын гол ажил нь «Ариун Ном» тэргүүтэй олон номыг монголоор орчуулж хэвлүүлэн, түүнээ өргөн олонд түгээж тархаах явдал юм. Тэдгээр номыг орчуулах, найруулах ажил Цахарын Шанд Адуучин хошууны Хадан Сөм гэдэг газар эрчимтэй өрнөж байсан бөгөөд их төлөв Христ шашинд орсон зарим монголчууд голлон, олон ном судар хэвлүүлж нийтэлжээ. Сонирхолтой нь, шашны номоос гадна монголчуудад зориулж, 1931 онд зохиосон «Angqan surqu köbegüüdi-g uduridun surYaaqu biçig» хэмээх сурах бичиг хэвлүүлсэн ажээ. Тэр нь монгол хэлний үндсэн мэдлэгээс гадна, Ариун Номын адил аж төрөх ёс журам, сургаал айлтгалыг Христ шашныхаа номлолын үүднээс тайлбарлан ойлгуулсан сурах бичиг байсан байна. Тус номын оршилд «Эзэн Чингис хааны үеэс уламжилж ирсэн монгол бичгээрээ төрийн ёсыг таниулж, хөвгүүд охидоо хүмүүжүүлж сургадаг асан уламжлал, заншил хэдэн зуун жил хаягдаж гээгдсэнд харамсаж, «Исүс бурханд итгэж шүтсэн бидний хэдэн хүн ... анхан сурах хөвгүүд дүү нарыг удирдан сургах хичээлийн бичиг» болгож, энэхүү номыг хэвлүүллээ гэдэг санаа бодлоо тодорхой үгүүлсэн байна.

Би тус илтгэлд нийт 36 хичээлээс бүтсэн энэ сурах бичгийг хэл шинжлэлийн талаас задлан шинжилж, хэл найруулгийнх нь онцлогийг тусгайлан авч үзэхийг зорьж байна.

МОНГОЛ ДАХЬ МАНЖ СУДЛАЛЫН БАЙДАЛ ХЭТИЙН ТӨЛӨВ

Тогтохын ОТГОНТУУЛ
Монгол Улсын Их сургууль

Түлхүүр үг: Манж сурвалж, манж хэлзүйн судалгаа, манж, монгол, солонгос хэлний харьцуулсан судалгаа

Манж улс 200 гаруй жил монголчуудыг эрхшээн захирч байсан ч хэл түүх, эдийн болон оюуны соёлын хувьд нэн эртнээс харилцаа холбоотой явж ирснийг түүхийн олон баримт гэрчилнэ. Тухайлбал, манж нар нэгэн хэсэг монгол бичгийг хэвээр нь хэрэглэж байгаад хожим дусал бинт тэргүүтэн ялгах тэмдэг нэмэх, зурлагыг өөрчлөх зэргээр хэл аялгуундаа тохируулан хэд хэдэн удаа засаж боловсруулан 1632 онд төрийн бичгээ зохиожээ. Ийнхүү богино хугацаанд бичгийн хэлтэй болж түүх, гүн ухаан, зан заншил, ёслол журам, сургаал, зурхай, уран зохиол болон шашны өдий төдий ном зохиолыг хятад хэлнээс орчуулснаас гадна манж хэлээр өөрсдийн бүтээн туурвисан зүйл ч арвин буй. Түүнээс багагүй бичгийн дурсгал Монголын Үндэсний Номын Сан, Монголын Үндэсний Архивын газарт хадгалагдаж байна. МУИС-д монгол хэлний салбарыг 1945 онд байгуулсан бөгөөд ямар ч нийгэм цаг үе харгалзахгүйгээр манж, төвд хэлийг сургалтад хамруулж, өнөөдрийг хүртэл тасралтгүй зааж, сургалт судалгааг хийж иржээ. Монгол манж хэл нь өвөг Алтайн хэлэнд багтдаг учраас зөвхөн Монгол төдийгүй нийт Алтай хэлний хөгжлийн онцлог, эртний махбодыг сэргээн судлахад манж хэл болон хоёр хэлний харьцуулсан судалгааг чухал бөгөөд энэ чиглэлийн судалгаа ч хийгдэж байна. Сүүлийн үед манж сурвалж судалгааг түлхүү анхаарч манжийн үеийн олон боть сурвалжийг монгол хэлээр орчуулах ажил өрнөж байна.

Д.НАЦАГДОРЖИЙН «ХЭЛХЭЭГҮЙ СУВД» ТУУЖИЙН ТУХАЙ

ДУЛААН
Бээжин Их Сургууль

Д.Нацагдоржийн «Хэлхээгүй Сувд» хэмээх тууж одоо болтол гүнзгий судлагдаагүй байна. Тус өгүүлэлд «Хэлхээгүй Сувд»-ын текст болон «Хэлхээгүй Сувд»-ыг бичихээр боловсруулж бэлтгэсэн төлөвлөгөөг Д.Нацагдоржийн бусад зохиолуудтай харьцуулан үзэж, «Хэлхээгүй Сувд» зохиолын зарим асуудлыг тодруулахыг оролдов. «Хэлхээгүй Сувд» зохиол Д.Нацагдоржийн томоохон хэмжээний роман тууж бичих төлөвлөгөөний чухал нэгэн хэсэг бөгөөд уг төлөвлөгөөнд боловсруулж байсан том зохиолынх нь агуулга нэлээд тодорч байсан байна. Мөн «Хэлхээгүй Сувд» нь бүлэгт романы зохиомжоор боловсруулагдаж байсан ба түүнд «Улаан Асрын Зүүдэн» «Эртэн Эдүгээгийн Гайхамшигт Үзэгдэл» зэрэг монголоор орчуулагдсан хятадын сонгодог зохиолын нөлөө харагдаж байна. Мөн Д.Нацагдоржоор «Хэлхээгүй Сувд»-аа хэдэн хүний хэдэн арван жилийн амьдралыг бичихээр бэлтгэж байсан төлөвлөгөөнөөс зохиолчоор өрнө дахины роман болон хятадын сонгодог зохиолын идэвхтэй нөлөөгөөр Монголын орчин үеийн анхны романыг туурвихаар бэлтгэж байсныг мэдэж болно. Мөн Д.Нацагдоржийн «Хэлхээгүй Сувд»-д текстийн нарийн задлалт хийхээр дамжуулж, одоо хүртэл олж харж дийлээгүй «Ордны Нууц» романы тухай элдэв зүйлийн таамгийн асуудлыг зарим талаар тайлбарлаж болох боломж нээгдэж байна.

PUBLIC CONSCIOUSNESS OF MODERN MONGOLIAN YOUTH: BASIC VALUES AND CHANGES

Innokentii G. AKTAMOV

Institute of Oriental studies of Buryat State University, Russia

The problem of studying the public consciousness of modern Mongolian youth seems to be very well-timed for scientific research in the context of the social science development and the Russian-Mongolian relations. The relevance of the project is that it will highlight those content and factors, which affect the nature and trends in the development of public consciousness of modern Mongolian youth, and, therefore, which are crucial for the understanding of prospective social behavior of the region inhabitants.

The study appears as one of sociological nature, because it deals with the social factors influencing the formation of public consciousness. Therefore methodological basis of the study is sociological approach. Furthermore, sociological approach of the study is combined with institutional methodology, explaining spiritual orientations and attitudes by influence of formal and informal rules and standards (institutions).

Scientific results of the project are: justification of the concept of public consciousness Mongolian Youth with current realities; selection of the main parameters that characterize the public consciousness; the study of socio-economic and spiritual, ethnic and cultural factors influencing the public consciousness (the practice of public institutions functioning), which will become a system description, thanks to exploration a variety of social phenomena: education, science, art, family, mass media, the government, political party, religion.

The project was implemented under the guidance of Professor Erdem D.Dagbaev (Sc.D., prof. of Buryat State University).

ҮНДЭСТНИЙ СЭТГЭЛГЭЭ, МЕТАФОРЫН УТГЫН ХАРИЛЦАН ХАМААРЛЫН АСУУДАЛ

Журын БАЯНСАН

Монгол улс, Соёл, Урлагийн их сургууль

Түлхүүр үг: Үндэстний сэтгэлгээ, үндэстний соёл, сэтгэлгээний тогтвортой хэв шинж, сэтгэлгээний жишиг хэмжүүр, үнэлэмж, метафор, утга, утга санаа, хамсмал утга, утга дүйх, багцалмал мэдлэг, ертөнцийн дүр зураг, ертөнцийн тухай хэлний дүр зураг,

Үндэстний сэтгэлгээ бүрэлдэн төлөвших зайлшгүй хүчин зүйлүүд гэвэл:

- Тухайн үндэстний эртнээс нааш амьдарч, аж төрж ирсэн газар нутгийн байгалийн тогтоц байдал, цаг уурын онцлог
- Тэндэхийн уул ус, ургамал мод, тэнд дасан зохицож, идээшин амьдардаг ан амьтан, араатан жигүүртэн, бусад амьтад, түүний төрөл зүйлийн онцлог
- Эртнээс нааш тэнд нутаглаж ирсэн үндэстэн угсаатны эд өлгийн болон оюун билгийн уламжлалт соёл, ёс заншил, шашин шүтлэг, эрхэлж ирсэн аж ахуйн төрөл зүйл, аж төрөх, амьдрах ухааны хэв шинж, өвөрмөц онцлог,
- Юм үзэгдэл, үйл явдал, шинж чанар, нөхцөл байдлыг эерэг, сөргөөр үнэлж цэгнэх арга ухааны онцлог юм.

Энэ нь тухайн соёл-хэлт үндэстний ертөнцийг үзэх үзэл, ертөнцийг таньсан байдлын хэв маяг буюу “Ертөнцийн тухай үндэстний дүр зураг” (World picture)-тай болж, улмаар Үндэстний сэтгэлгээ үүсэн бүрэлдэж, төлөвшин тогтох үндэс суурь болно.

Тэгвэл тухайн үндэстний бүтээн цогцлоож, өвлөн уламжилж ирсэн соёлын зүйл, түүнд шууд холбогдолтой сэтгэлгээнийх нь онцлогийг хэлний тэмдэг буюу хэлээр илэрхийлэх хамгийн зохистой арга хэрэглүүрийн нэг нь тэдний хэлний Метафор болох юм. Метафорыг өргөн утгаар нь авч үзвэл зүйр цэцэн үг, өвөрмөц хэллэг, ёгтлол, егөөдөл, хэтрүүлэл (ихэсгэл багасгал), тойруулал, эерүүлэл зэрэг дүрслэх ур маягийн бүх төрлийг багталцуулан хэлэлцэх боломжтой юм. Ингэхлээр Метафор бол тухайн хэлний аливаа илэрхийлэл биш, харин тухайн төрөлх хэл-соёлтны уламжлалт соёлын тухай утга, утга санааг нэвтрүүлэн тээгч онцгой хэрэглүүр, онцгой тэмдэг гэж үзэх учиртай болж байна. Өөрөөр хэлбэл, Метафор бол хэлж сэтгэх хийсвэрлэлийн хамгийн дээд эрэмбийн үзэгдэл, дээд эрэмбийн илэрхийлэл болно. Үүнийг ерөнхийд нь “ертөнцийн тухай үндэстний хэлний дүр зураг” гэж томъёолон хэлэлцдэг болжээ. Харин ертөнцийн тухай ерөнхий дүр зураг нь өөр өөр соёл-хэлт үндэстний хувьд нийтлэг байж болно. Энэ нь хүн төрөлхтний

сэтгэхүйн нийтлэг шинжээр нөхцөлдсөн боломж ажээ. Ихэнх метафорчилсон илэрхийллийн “шууд утга” нь гэнэн (naive) танилт байдаг учраас үүнтэй эсрэгцүүлэн “ертөнцийн тухай шинжлэх ухааны дүр зураг” хэмээх гэдэг ойлголт, томъёоллыг хэрэглэх нь ч үзэгдэх болжээ.

Хэлний метафорыг судлан тайлбарлахдаа зөвхөн Хэлшинжлэлийн ухааны (Linguistics) онол аргазүйгээр хязгаарлалгүй, харин түүнийг Сэтгэл судлал (Psychology), Соёл судлал (Culturology), Угсаатан судлал (Ethnology), Нийгэм судлал (Sociology), Хүн судлал (Anthropology), Нийгэм-соёлын хүн судлал (Socio-cultural Anthropology), Таньхуй судлал (Cognitive Theory) зэрэг Хүнийг судалдаг Хүмүүнлигийн ухаануудын уулзвар дээр судлан тайлах зайлшгүй шаардлагатай болж байгааг энэ илтгэл-өгүүллийн онол, аргазүйн үндэс болгосон юм.

Энэ илтгэлдээ зүйр цэцэн үг, өвөрмөц хэллэг зэрэг хэлний тогтвортой илэрхийллийн утгаас тухайн соёл-хэлтний үндэстний уламжлалт соёл, ертөнцийг таньсан байдал, ертөнцийг үзэх үзэл, сэтгэлгээ, үнэлэмжийнх нь онцлогийг танин тайлах аргазүйн боломжийг судлан шинжилж, зохих гаргалга дүгнэлтэд хүрснээ толилуульж байна.

**MONGOLIA OF THE 20TH CENTURY BEGINNING
IN THE NOVEL BY G.AYURZANA
“SACRED HANGAY’S SECRET”**

PETROVA MARIA
Saint-Petersburg State University

Keywords: Novel, magical realism, protagonist

Modern Mongolian writer G. Ayurzana (born in 1970) is well known to the readers for his novels “The Shaman’s Legend” (2010), “Shugden” (2012), “White, Black, Red” (2014), “Pulsation” (2015) . The novel “ Sacred Hangay’s Secret” (2017) is written in the style of magical realism. Novel’s time is the end of the Tsins rule, the years of Mongolia’s independence, People’s Revolution victory. Novel’s protagonist is the last ruler of one of the khoshuns Purev gun. Special attention in the novel is paid to change of human essence and worldview, produced by historical events (the course of time). This is the period of significant social upheaval in the country. The author combines everyday life description with fantastic and magical one, as in the famous novel by Latin American writer G.Markes “One Hundred Years of Solitude.”

**МОНГОЛ ХЭЛЭЭРХ АНХНЫ СОНИН БУРИАД-МОНГОЛЫН
«ДОРНО ЗАХ ХЯЗГААРЫН АЖ ТӨРӨЛ» (1895-97 ОН):
ХЭЛ СОЁЛ, НИЙГЭМ ТҮҮХ СУДЛАЛЫН ЧУХАЛ БАРИМТ**

Бадагаров ЖАРГАЛ

Хайдэлбэргийн Их Сургууль/Буриад Улсын Их Сургууль

Тус илтгэлд монгол хэлээр гарсан анхны сонин болох буриад-монголын «Дорно зах хязгаарын аж төрөл» хэмээх сонингийн тухай товчхон өгүүлнэ. Энэхүү «сонинт бичиг» нь 1895-97 онд Чита хотод орос монгол хоёр хэлээр хэвлэгдэж байсан бөгөөд эрхлэгч нь П.А.Бадмаев байжээ. Оросын хааны шадар эмч, улс төрийн зөвлөгч, нийгмийн зүтгэлтэн, үйлдвэр худалдаа эрхлэгч байсан тэрбээр сонин байгуулж дорно дахины ард түмэнд Орос орны таатай дүр зургийг бүрдүүлэх нь чухал гэж үзэж байсан нь энэ сонинг үндэслэн байгуулах гол шалтгаан байв. Илтгэгч тус сонинг хэдэн жил хайсны үр дүнд иж бүрэн цуглуулгыг саяхан амжилттай илрүүлсэн үндэс суурин дээр тус сонингийн тухай анхлан танилцуулж эрдэмтэн мэргэдийн анхааралд хүргэхийг зорих болно. Монгол сонин сэтгүүлийн үүсэн бүрэлдэх тухайн үеийн чухал баримт болохоор барахгүй хэл соёл, нийгэм улс төр, түүхийн олон төрлийн судалгаанд дутагдаж болшгүй сурвалж болох энэхүү хэвлэлийн ач холбогдолыг тодорхой жишээгээр үзүүлэхийг хичээнэ.

**THE BIRTH OF JOURNALISM IN MONGOLIC:
«LIFE OF THE EASTERN FRONTIER»
IN BURYAD-MONGOL (1895-97)**

JARGAL Badagarov

Heidelberg University/Buryat State University

The author presents a brief description of the first newspaper in a Mongolic language — «Dorun=a jaq=a kijayar-unaju törül» («Life of the Eastern Frontier») which was published in Buryad and Russian in Chita during 1895-97. Its founder Peter Badmaev was a personal doctor, and an advisor of the Russian tsar, an eminent political figure and businessman. The newspaper aimed at promoting a positive image of Russian Empire among «Eastern» nations. An almost complete set of the newspaper has been found recently as a result of a longstanding search by the author. This gives us an opportunity to examine it in detail. «Life of the Eastern Frontier» gives us an outstanding set of materials for historical, political, linguistic, anthropological and cultural studies of one of the most interesting periods in the modern history of Mongolic people.

ХАЛХ АЯЛГУУНЫ ҮГИЙН ТЭРГҮҮН ҮЕИЙН ТАГНАЙ-ХӨӨМИЙН БОГИНО ЭГШИГ

Ц.БАТДОРЖ

*ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн
Эрдэмтэн нарийн бичгийн дарга, доктор (Ph.D)*

Зохиогч тус илтгэлдээ, монгол хэлний авиа зүйн уламжлалт судалгаанд /a/, /o/, /u/ гурван богино эгшиг авиалбарын эс тагнайшсан хувилбар гэж үздэг [a], [ɔ], [ʊ] гурван богино эгшиг авиа ба тагнайшсан хувилбар гэж үздэг [æ], [œ], [ʏ] гурван богино эгшиг авиаг туршилт авиа зүйн судалгааны дууны ухааны арга (acoustical method) болон сонсголын туршилтын арга (auditorial method)-аар нягтлан шинжилсэн дүнгээ танилцуулжээ.

Авиа зүйн түвшинд: Уламжлалт авиа зүйн судалгаанд орчин цагийн монгол утга зохиолын хэлний суурь халх аялгууны “хань”, “охь”, “хувь”, “аргил”, “тариа”, “горим”, “хуримлах” гэх мэт үгийн тэргүүн үеийн богино эгшгүүд болон “жаргал”, “чоно”, “шувуу” гэх мэт үгийн тагнайн гийгүүлэгч, шүд-тагнайн гийгүүлэгчийн орчинд тохиолдох богино эгшгүүд нь авианы ялгаруулах шинжийн хувьд яг ижилхэн [æ], [œ], [ʏ] эгшгүүд гэж үзсээр ирсэн билээ. Гэвч, зохиогч дээрх эгшгүүдийг туршилт авиа зүйн судалгааны дууны ухааны аргаар судлаад “хань”, “охь”, “хувь”, “аргил”, “тариа”, “горим”, “хуримлах” гэх мэт үгийн тэргүүн үеийн богино эгшгүүд болон “жаргал”, “чоно”, “шувуу” гэх мэт үгийн тагнайн гийгүүлэгч, шүд-тагнайн гийгүүлэгчийн орчинд тохиолдох богино эгшгүүд нь авианы ялгаруулах шинжээр эрс ялгаатай болохыг тодруулжээ.

Авиалбар зүйн түвшинд: Уламжлалт авиа зүйн судалгаанд халх аялгууны “хараа”, “орон”, “хурал” гэх мэт үгийн тэргүүн үеийн [a], [ɔ], [ʊ] богино эгшгүүд болон “заль”, “жаргал”, “хонь”, “чоно”, “улирал”, “шувуу” гэх мэт үгийн тэргүүн үеийн [æ], [œ], [ʏ] эгшгүүд нь харилцан нөхөх байрлалд тохиолдох тул /a/, /o/, /u/ гурван богино эгшиг авиалбарын эс тагнайшсан ба тагнайшсан хувилбарууд мөн гэж үзэж ирэв. Харин зохиогчийн хийсэн дууны ухааны болон сонсголын туршилтын үр дүнг үндэслэвэл дээрх эгшгүүд нь харилцан биенээ үл нөхөх байрлалд тохиолдож, /a/, /æ/, /ɔ/, /œ/, /ʊ/, /ʏ/ гэсэн биеэ даасан авиалбарууд болох ажээ.

**ЗӨВЛӨЛТИЙН ЗӨВЛӨХ Г.П.СЕРДЮЧЕНКО БА
ӨВӨР МОНГОЛЫН СТАНДАРТ ХЭЛ: АРХИВЫН
МАТЕРИАЛУУДААС 1950-ААД ОНЫ БНМАУ БА ӨВӨР
МОНГОЛЫН ХЭЛНИЙ ХАРЬЦААГ АВЧ ҮЗЭХ НЬ**

ХӨХБААТАР

Шоова Эмэгтэйчүүдийн Их Сургууль, Япон

XX зуунд монголчууд орчин үеийн тусгаар улсыг байгуулж чадснаараа, дэлхийн ба Азийн улс үндэстний хөгжлөөс хоцролгүй «nation state» хэмээх «үндэстний улс»-ыг бий болгож чадсан байна. Түүний дагуу «national language» ч бий болох буюу бий болгох боломжтой болсон байна. Гэхдээ тэр боломж нь зөвхөн тусгаар тогтнолоо олсон Ар монгол буюу 1924 оноос хойших БНМАУ-д л байснаас биш, Өвөр Монгол буюу Хятадын хил хязгаарт байсан монголчуудын хэл аялгуу нь ямар байх ёстой вэ гэдэг асуудал нь, онолын хувьд ч практикийн хувьд ч сонирхолтой бөгөөд чухал асуудал байлаа. Энэхүү тулгам зангилагын асуудалд дээр 1950-аад оны дунд үеэр БНХАУ-д хэл шинжлэлийн ухааны зөвлөхөөр ажиллаж байсан ЗХУ-ын эрдэмтэн Г.П.Сердюченко маш чухал зөвлөгөө өгсөн байв. Түүний тэр зөвлөгөө нь 1950-аад оны БНМАУ ба Өвөр Монголын монгол хэлний харьцааг судлахад ба эдүгээгийн хоёр орны хэлний харьцааг ойлгоход чухал ач холбогдолтой байгаа гэдгийг тус илтгэлдээ өгүүлэх болно.

Г.П.Сердюченко нь 1954 оны 10 дугаар сараас 1957 оны 7 дугаар сар хүртэл Хятадын Нийгмийн Шинжлэх Ухааны Хүрээлэн, Төвийн Үндэстний Дээд Сургуульд ажиллаж байхдаа үндэстний цөөнхийн хэлний судалгааны ажлыг удирдан, Хятад хэл ба хэлний цөөнхийн стандарт хэлний онолын суурийг тавьсан байна. Түүнээр Сердюченко нь БНХАУ-д “Октябрийн хувьсгалын загалмай зүүсэн эрдэмтэн” хэмээн маш их нэр хүндтэй байв. «Нийгэм журмын үеийн стандарт хэл ба феодлын нийгмийн стандарт хэлний ялгаа»-г тайлбарласан түүний үзэлт нь, сонгодог монгол бичгийн хэл ба орчин цагийн монгол хэлний ялгаа ба харьцаа холбоотой дүйж байгаа гэдэг утгаараа, өнөөдөр бид “орчин цагийн монгол хэл”-ийг мөн чанараас нь ойлгоход маш сонирхолтой онолын баримт болох болно. Тэрээр Өвөр Монголын монгол хэл аялгууны стандарт хэлний тухай өгүүлэхдээ, “Халх аялгуу нь аль их хөгжсөн. БНМАУ нь түүнээр стандарт хэл болгоод 30 илүү жил болж байна. Өвөр Монголын сэхээтэд ч тэр тал руугаа хандсан байдаг. Тэгээд ч Халх аялгуу нь Өвөр Монголын аялгуунуудтай нэг их зөрөхгүй. Тэгэхээр халх алгуугаар суурь аялгуу болгож болно, харин судалгааныхаа материалыг харах хэрэгтэй” гэж тодорхой мөртлөө болгоомжтой хэлсэн байдаг. Түүний дараа БНХАУ-д хийсэн монгол хэл аялгууны судалгааны үр дүнд, Өвөр Монголд БНМАУ-ын стандар хэл, стандарт дуудлагыг дүрэмжүүлэх тухай “төсөл” гарсан байв. Тус илтгэлд Өвөр Монголын архивт байгаа тухайн үеийн ӨМӨЗО-ны материалуудыг шинжлэх болно.

БИЧИГ ҮСГИЙН ТАЛААРХ МОНГОЛ УЛСЫН ТӨРИЙН БОДЛОГО, БОДИТ ХЭРЭГЛЭЭ, ОЛОН НИЙТИЙН ҮЗЭЛ ХАНДЛАГА

Д.ЗАЯАБААТАР
Монгол

Монгол Улс өнөөдөр кирил бичгийг албан хэрэглээнд ашиглаж байна. Гэвч монгол бичгийг төрийн албан бичиг болон олон нийтийн хүрээнд зохих хэмжээгээр хэрэглэх байдал бий. Олон нийтийн дунд бичиг үсэг солих талаар кирил бичгийг хэвээр байлгах, монгол бичгийг төрийн бичиг болгох гэсэн хоёр туйлт үзэл хандлага гардаг. Улмаар 2015 онд батлагдсан “Монгол хэлний тухай хууль”-д 2025 оноос эхлэн хос бичгийг хэрэглэх тухай заалт ч орсон юм.

Энэхүү илтгэлд дараах асуудлыг хөндөнө:

1. Бичиг үсгийн талаарх төрийн бодлого
2. Монгол ба кирил бичгийн өнөөгийн бодит хэрэглээ
3. Хоёр бичигт хандах олон нийтийн үзэл

Цаашид монгол ба кирил бичгийн хэрэглээний байдал хэрхэн өөрчлөгдөх, түүнд нөлөөлөх олон нийтийн болон төрийн бодлогын хүчин зүйлс юу болох талаар тодруулан үзнэ. Мөн “Монгол хэлний тухай хууль”-д заасанчлан монголчууд хос бичгийг хэрэглэх боломж бий эсэх, энэ асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар өөрийн санааг дэвшүүлэх болно.

STATE POLICY, PUBLIC ATTITUDE AND PRACTICAL USE OF SCRIPTS

ZAYABAATAR D.,
Mongolia

Today, Cyrillic Mongolian alphabet has been used as the official writing system in Mongolia. However, the traditional script known as an old Mongol script is still being used in the governmental documents and public sphere. There are two-pronged public attitudes toward changing scripts: continue using Cyrillic Mongolian while using Mongol script as a state language. There is even an article in “Law on Mongolian language” which states that two scripts shall be simultaneously used starting from 2025.

The following issues shall be discussed in this presentation:

1. State policy on language and literacy
2. Current practical use of Cyrillic Mongolian and Mongol script
3. Public attitudes towards two scripts

Author clarifies how the use of Cyrillic Mongolian and Mongol script will change in the future and what public and political influential factors it will have. Furthermore, he proposes his own ideas on whether the Mongolians have possibilities of using these two scripts as it was included in the Law on Mongolian language or not, and what literacy skills of Mongol script the public has now in reality.

КИРИЛ БИЧИГИЙГ АВЧ ХЭРЭГЛЭСЭН ТУРШИЛГА

Д.ТӨМӨРТӨГОО

1. Монголчууд бол минга гаруй жилийн түүхтэй үсэг бичигийн баялаг уламжилалтай үндэстэн билээ. Бидний өвөг дээдэс манай эриний IX-X зууны үед арван дөрөвхөн үсэгтэй уйгур үсэгийг авч, эх хэлнийхээ бүтэц, тогтолцоонд тохируулан нэмэн засаар XIV зууны үед эх хэлнийхээ авианы бүрэлдэхүүн, үгийн бүтэцийг бүрэн зөв тусхасан үндэсний үсэг бичигтэй болж, олон арван бичигийн дурасхал үлдээжээ. Тэдгээр бичигийн дурасхалаас мингаад жилийн тэртээх монгол хэлний бүтэц, тогтолцоог бүрэн тодорхой мэдэх боломжтой байгаа билээ.

Эртний монгол хэлний онцлог шинж дээр түшиглэн хэвшин тогтсон монгол бичигийн хэл нь яваандаа аман ярианы хэлнээсээ хоцорч, бичигийн хэл, ярианы хэл хоёр өөр хоорондоо нилээд зөрөөтэй болжээ. Тийм учираас хэл яриандаа тохирсон үсэг бичигтэй болох хандлага удаа дараа гарч, түүний үр дүнд дөрвөлжин бичиг, тод бичиг, соёмбо бичиг гэх мэт хэд хэдэн өөр үсэг бичиг зохиогдсоор ирсэн билээ. Хэдий тийм боловч монгол бичиг нь сонгодог уламжилалаа тогтвортой хадгалж, монгол үндэстэний бичигийн үүрэгээ хадгалсаар ирсэн билээ.

Хорьдугаар зууны эхээр Монгол оронд нийгэмийн хувисхал гарч, ард олоноо соён гэгээрүүлэх, бүх нийтийг бичигтэн болгож, орчин үеийн соёл, шинжилэх ухааны ололттой танилцуулах томоохон зорилт тулгарсан билээ. Тэрхүү зорилтыг хэрэгжүүлэхийн тул аман ярианы хэлэндээ ойр, сургахад хилбар, сурахад амар үсэг бичигийг нэн шаардлагатай болжээ. Тийм учираас орос үсэгийг авч хэрэглэх шинэ шийдвэр гарч, түүнийгээ хэрэгжүүлэх ажилыг эрчимтэй эхэлсэн байна.

Кирил үсэгийг нийтээр авч хэрэглэх засагийн газарын шийдвэр гарсаны дараа бүх шатны сургуулиудад шинэ бичигийг заан сургах ажил эрчимтэй өрнөсүүлсэний дээр бүх сонин хэвлэлүүд кирил бичигээр гарах болжээ. Түүнчилэн орон даяар шинэ бичигт сургах богино хугацааны дугуйлангууд байгуулагдаж, тэдгээрт үйлдвэрийн ажилчин, хөдөөний малчид хамарагдан хэдхэн жилийн дотор нийт хүн амын талаас илүү хувь нь бичиг үсэгтэн болж чаджээ. Тийнхүү бүх нийтээр бичигтэн болсоноор үндэстэнийхээ түүх соёлын уламжилал төдийгүй дэлхийн соёл, шинжилэх ухааны арвин баялаг өв сантай танилцаж, орчин үеийн соёлт үндэстэнүүдийн нэг болж чадсан нь XX зууны Монголын нийгэмийн амьдаралд гарсан чухал өөрчилөлтийн нэг болсон байна.

Өнөөдөр Монгол уласын бүх шатны сургууль, соёл, шинжилэх ухаан, хэвлэл мэдээлэл, төрийн бүх албан хэрэг гагцхүү кирил үсэг дээр суурилсан монгол бичигийн хэлээр явагдаж байна. Түүгээр ч үл барам дэлхийн соёл, шинжилэх ухааны олон зуун шилдэг бүтээлүүд кирил үсэгээр хэвлэгдэж, монгол түмэний оюуны хэрэгцээг хангасаар иржээ.

2. Монгол кирил бичигийн зөв бичих дүрэм. Одоогийн мөрдөж байгаа монгол кирил үсэгийн дүрэмийн үндэсийг анх боловсоруулахдаа тухайн үеийнхээ монгол хэлний судалгаанд түшиглэсэн байна. Хэдий тийм боловч монгол хэлний урт удаан түүхэн хөгжилийн явцад авианы бүтэц, бүрэлдэхүүнд гарсан хувьсалыг түүхэн үүднээс судалан тайлбарласан бүтээл ховор байсан учир үсэгийн дүрэмийг хэл шинжилэлийн үүднээс тогтооход амаргүй байсан нь мэдээж хэрэг. Тийм ч учираас зарим авианы дотоод хувьсалыг өрөөсхөлөөр таньсан нь кирил бичигийн зөв бичих дүрэмд гарсан гажуудалын үндэсэн шалтгаан болсон байна.

Кирил үсэг авч хэрэглэсэний 15 жилийн ойг тохиолдуулан Улаанбаатар хотод зохион байгуулсан олон уласын эрдэм шинжилгээний хурал дээр анай ахмад үеийн нэрт эрдэмтэд болон Монгол, ЗХУ, Хитад, Финландын эрдэмтэд одоогийн мөрдөж байгаа кирил бичигийн зөв бичих дүрэмд үгзүйн зарчмыг голлон баримталж, үгийн үндэс, язгуурыг тогтвортой болгох талаар санал нэгдэж байсан билээ. Монгол хэлний бодит тогтолцоог тусхасан тэдгээр саналуудыг тэр дор нь хэрэгжүүлсэн бол өнөөдөр бид үсэгийн дүрэмийн аар саархан зүйл ярьж байхгүй, харин цахим орчин дахь бичигийн хэлний дүрэм, компьютер хэл шинжилэлийн түвшиний асуудал ярьж байх байсан.

Шинжилэх ухаан-технологи асар түргэн хөгжиж байгаа одоо үед боловсоронгуй бичигийн хэл улам илүү шаардлагатай болж байна. Нөгөө талаар, уламжилалт монгол бичигийн хэрэглээ нэмэгдэж, компьютерийн тусламжтайгаар олон төрөлийн зориулалт бүхий толь бичиг боловсоруулах, үгийн бүтэц, үгсийн сангийн статистик судалгаа хийх бодит шаардлага улам бүр нэмэгдсээр байна. Ийм нөхцөлд эх хэлнийхээ бодит тогтолцоог нарийн зөв тусхасан цөөн тооны цомхон дүрэм боловсоруулж, түүнийгээ компьютер хэл шинжилэлийн түгээмэл хөтөлбөрт таниулан тал тал тийшээ хөрвөх өргөн боломжтой болгон хөгжүүлэх нь нэн чухал болж байна.

Орчин үеийн бичигийн хэлний бодит шаардлага бол одоогийн даган мөрдөж байгаа кирил үсэгийн зөв бичих дүрэмээс хэрэгцээ багатай, хүндэрэл ихтэй, гажилт олонтой зохиомол дүрэмүүдийг хасаж, хүн ч амархан сурдаг, машин ч хялбархан таньдаг цөөн тооны үндэсэн дүрэмийг цаг алдалгүй боловсоруулан мөрдүүлэх нь өнөөгийн боловсорол, шинжилэх ухааны эрх ашигт адил тэгш нийцнэ.

Ардчилал, хүний эрх, шинжилэх ухааны эрх чөлөөг эрхэмлэн дээдлэж, боловсорол, шинжилэх ухаан, технологийн олон салбар асар хурдацтай хөгжиж байгаа өнөөгийн нөхцөлд бичигийн хэлээ улам боловсоронгуй болгож, хэлнийхээ бодит тогтолцоог илүү зөв тусхасан сайн дүрэмтэй болох боломж урьд урьдаас илүү бүрэлдэж байгаа биш үү.

МОНГОЛ ДАХЬ ТӨВӨД СУДЛАЛЫН ТӨЛӨВ БАЙДАЛ: ӨНГӨРСӨН БА ОДОО

О.ДЭМЧИГМАА
Монгол Улсын Их сургууль

Түлхүүр үг: Монгол судлал, төвөд судлал, төлөв байдал

Төвөд хэлийг бурханы шашны хэл гэдгийг хэн бүхэн мэдэх хэдий ч шинжлэх ухааны төрөл бүрийн салбарын зохиол бүтээл энэ хэлээр уламжилж ирснийг тэр бүр мэддэггүй гэхэд болно.

Монголын төвөд судлал гэдэг бол үнэн хэрэгтээ Төвөд орныг судлах тухай асуудал бус бөгөөд төвөд хэлээр уламжилж ирсэн, монголын өв соёлыг судална гэсэн үг юм. Учир юун хэмээвээс 16 дугаар зуунаас Монголд бурханы шашин 3 дахь удаагаа нэлээд эрчимтэй, өргөн далайцтай дэлгэрч эхэлснээс хойш 20 дугаар зууны эхэн үе хүртэл төвд хэл монголчуудын хувьд эх хэлтэй эн зэрэгцэхүйц түвшинд хэрэглэгдэж, утга зохиолын хэлний хэм хэмжээнд хүрч байсан байна. Үүний дүнд төвд хэлээр 300 гаруй монгол эрдэмтэн лам буддын их, бага таван ухаанаар 1-27 хүртэлх боть зохиолыг туурвин бидний үед үлдээснийг судлаачид тэмдэглэсээр байгаа билээ.

Шинжлэх ухааны олон салбарыг хамарсан энэхүү арвин баялаг өв санг судлах нь ихээхэн ач холбогдолтой бөгөөд судлан шинжлэх ажлыг эрдэмтэд 20 дугаар зууны дунд үеэс эхэлж, мөн зууны сүүл үе буюу Монгол орон ардчилсан нийгэмд шилжсэнээс хойш эрчимжиж байна. Үүнээс өмнө нийгэм харьцангуй хаалттай байсан төдийгүй 1930-1940-өөд оны хувьсгалын их шуурга төвөд хэлт монголын өв соёлд үлэмж сөргөөр нөлөөлсөн бололтой.

Эдгээр бүтээл туурвилыг жинхэнэ эхээс нь судлан эрдэм шинжилгээний эргэлтэд оруулахын тул төвөд бичгийн хэлийг сурч судлах шаардлага зүй ёсоор гарна. Энэ учир зорилгын үүднээс аливаа зүйлийн наад цаад мөн чанарыг сайтар ухаардаг ахмад эрдэмт багш нарын зүтгэлээр Монгол Улсын Их сургуулийн монгол хэл, утга зохиол судлалын оюутнуудад төвөд хэлийг 1956 оноос зааж эхэлсэн нь тус чиглэлээр судлаач, мэргэжилтэн бэлтгэх эх суурь болсон юм.

Түүнээс хойш олон арван судалгааны бүтээл, орчуулга, толь бичиг хэвлэгдсэний зэрэгцээ Эх бичиг-Алтай судлалын тэнхимийн оюутнууд, магистрант, докторант нар төвөд сурвалжуудын талаар чамгүй олон судалгааны ажлыг хийгээд байна.

BIBLICAL TRANSLATION IN MONGOLIC LANGUAGES IN RUSSIA, -AN OVERVIEW

Arai YUKIYASU

*Co-researcher of Slavic-Eurasian Research Center,
Hokkaido University*

Since Kalmyks and Buryats became the subject of Russian Empire, there were many Christian missionaries, the catholic at the beginning and later the orthodox, are trying to Christianize Mongolic people in Russia. For that, many missionaries made several attempts to make translations of Bible, in some case total translation, and in many cases only partial translations. At this presentation I would try to give a brief information on attempts of the Bible translation from 18th century until the Russian Revolution.

МОНГОЛ ХЭЛНИЙ ТОГТВОРТОЙ ХЭЛЛЭГТ ҮНДЭСТНИЙ СЭТГЭЛГЭЭНИЙ ӨВӨРМӨЦ ОНЦЛОГ ТУССАН НЬ

С.ЭНХЖАРГАЛ

ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэн, Монгол

Аливаа ард түмний сэтгэлгээ нь хэлээрээ дамжин илэрч байдаг зүй тогтолтой тул монгол хэл, монгол сэтгэлгээ, монгол аман соёлын онцлогийг хадгалсан монгол хэлний тогтвортой хэллэгүүдийн ерөнхий бүтэц, загвар, үг хэллэгийн онцлогийг танин мэдэхүйн хэл шинжлэл, сэтгэц хэл шинжлэл, хэл-соёл судлалын уулзвар дээр өргөн хам хүрээнд судлан тодруулах явдал улам бүр хүчээ авсаар байна.

Монгол хэл-соёлт үндэстэн байгаль дэлхий, хүний амьдралд оршиж бас орчиж байгаа элдэв юм үзэгдэл, үйл явдал, шинж чанарыг таньж мэдээд, түүнийгээ үнэлсэн байдал, энэ үнэлэмжийнх нь жишиг хэмжүүр юу болох, түүнийгээ ямар аргаар, хэлний ямар нэгжээр илэрхийлдэг болохыг судлах нь нэн сонирхолтой асуудал юм. Монголчуудын танин мэдэхүйн хийгээд үндэстний сэтгэлгээний өвөрмөц шинж нь тэдгээрийн уламжлалт соёл, зан үйлийг тээгч тогтвортой үг хэллэгийн утга агуулгаар илэрч байдаг билээ. Монгол хэлний тогтвортой хэллэгийн шилдэг жишээ бол төрөл бүрийн хэлц хэллэг, цэцэн үг, зүйр үг, сургаал үгс, ертөнцийн гурав зэрэг болно. Эдгээр нь монголчуудын олон мянган жилийн турш аж төрөн амьдарч ирэхдээ цуглуулсан мэдлэг, туршлагын хуримтлал болохын хамт монголчуудын хувьд үнэн гэж үздэг бүхнийхээ тухай толгой холбон шүлэглэсэн уран хэллэгийн дээж, хийсвэрлэн сэтгэх үйлийн үр дүн байдаг. Хийсвэрлэл бол юмсын гол шинж, холбоо хамаарлыг таньж, бодит тодорхой байдлаас нь хөндийрч, түгээмэл зүйлийг нь танин мэдэх сэтгэхүйн хэлбэр бөгөөд адилтган зүйрлэх, төлөөлөн илэрхийлэх сэтгэлгээгээр илэрдэг. Орчин үеийн хэл шинжээчид зүйрлэлийг сэтгэхүйн үндсэн үйл ажиллагаа, ертөнцийг танин мэдэх, тайлбарлах, бүтэцлэх арга гэж үзэж байна. Хүн, зүйрлэлийн тусламжтайгаар өөрийн санааг илэрхийлээд зогсохгүй, зүйрлэлээр сэтгэж, зүйрлэлийг хэрэглэснээр өөрийн гэсэн ертөнцийг үүсгэдэг ажээ. Өөрөөр хэлбэл, ертөнцийн юмс үзэгдлийг яг байгаагаар нь шууд бус, ерөнхийд нь өөрсдийн ахуй амьдралтай холбож хийсвэрлэн тусгаж, дүрслэн илэрхийлдэг нь хүн төрөлхтний танин мэдэхүйн онцгой чухал арга барил байдаг. Монголчуудын хувьд ч ертөнцгэй харьцах явцад өөрийн бие, орчин тойрны хэрэг бодис, юм, үзэгдэл, орон, хөдөлгөөн зэргийг танин мэдэж, хамгийн анхны бодитой ухагдахууныг бүрэлдүүлэхийн зэрэгцээ бодитой, хэлбэр дүрстэй ухагдахуунаа ашиглаж, хэлбэр дүрсгүй хийсвэр зүйлийг ойлгож, танин мэдсэнээ төрөл бүрийн тогтвортой хэллэгийн утга агуулгад шингэн хадгалж ирсэн байна. Монгол хэлний тогтвортой хэллэгт аливаа хийсвэр юм үзэгдлийг дүрслэн үзүүлэхдээ ил ба далд зүйрлэлээр илэрхийлж, нүүдэлчдийн орон зай, цаг хугацааны мэдрэмж хийгээд үнэт зүйлсийн тогтолцоог суурин иргэншилтэй улс үндэстнээс ялгаатай болохыг харуулж байдаг. Тэрчлэн аль нэгэн хийсвэр зүйлийн шинжийг бодит юм үзэгдлийн шинжтэй зүйрлэн тухайн хийсвэр шинжит зүйлийг боджуулан биежүүлдэг, эсвэл амьджуулан дүрсэлдэг онцлогтой болохыг зарим үг хэллэгийн жишээгээр тайлбарлан өгүүлэв.

TALK ON THE SEAL OF IMPERIAL TUTOR CHANGKYA HUTUKTU

BAATAR C.H. HAI

Counselor, Ministry of Culture, R.O.C

The discussion of this thesis is divided into 7 parts: 1. Explaining the intention of writing this thesis. 2. Introducing Yonghe Temple's collection and exhibition of the seals of Imperial Tutor Changkya Hutuktu. 3. Exploring the origin of the usage of Phagspa character to engrave the seals by Imperial Tutor the 3rd Changkya Hutuktu. 4. Exploring the background and explaining the personal jade seal of Imperial Tutor Changkya Hutuktu through the official seal system of Qing Dynasty. 5. Brief explanation on the change and recasting of the official seal of Qianlong. 6. List of the seals and titles of successive Changkya Hutuktus according to the present historical records. 7. Explaining through pictures the official and personal seals used by the 7th Changkya Hutuktu in Taiwan.

ШВЕДИЙН ШАШИН ДЭЛГЭРҮҮЛЭГЧИЙН КАМЕРТ БУУСАН МОНГОЛЫН НИЙГЭМ

Төвчүүд БАЙГАЛЬ
Япон Оберлин их сургууль

Шведийн шашин дэлгэрүүлэгч Joel Eriksson (1890-1987) бол алдарт эмч юм. Тэрээр 1913-1939 он хүртэл Шведийн монгол дахь шашин дэлгэрүүлэх газрыг голлон хариуцаж Цахарын шанд адуучин хошууны халуун ус (Одоогийн Өвөр Монголын Улаан Цав хотын Хуа Дэ Шиен)-аар суурин болгож тухайн үеийн өргөө (Одоогийн Улаанбаатар 1919-1924) Цахарын Гөл Цагаан (Одоогийн Өвөр Монголын Шилийн гол аймгийн Хөвөөт Шар хошуу 1922-1943) Доён (Одоогийн Өвөр Монголын Шилийн гол аймгийн Шулуун Хөх хошуу 1924-1943) зэрэг газар салбар өртөө байгуулан ажиллажээ. 1928 онд Шведийн Монгол дахь шашны төв нь Халуун уснаас Хадан сүм (Одоогийн Өвөр Монголын Шилийн гол аймгийн Хөвөөт Шар хошуу 1928-1944)-т шилжжээ. Eriksson энэхүү шашин дэлгэрүүлэх газрууддаа өмчлөн суусан төдий биш юм. Хаалган, Хөх хот, Дархан Муу мянган хошуу, Дөрвөд хошуугаар аялан явж байсныг түүний авсан гэрэл зургуудаас харж болно.

Eriksson Монголд байх хугацаандаа 1400 шахам гэрэл зураг авсан байдаг бөгөөд үүнд тэдний шашин дэлгэрүүлэх ажиллагааны зураг голчилсон байдаг. Түүнээс гадна Дэ Ван, Дилав хутагт зэрэг нэрт хүмүүсийн ховор зураг ч багтсан байдаг. Мөн сүм хийд, хот суурин, орон сууц, ажил амьдрал, найр наадам, зам тээвэр, цэрэг зэвсэг, хувцас засал, байгаль орчин, гамшиг зуд, өвс ургамал, хээрийн амьтан зэргийн гэрэл зураг ч цөөнгүй байдаг.

Eriksson-ны авсан гэрэл зургийн олонхийг нь Uppsala их сургуулийн номын санд хадгалж байна. Улсын архив, угсаатны музей болон хувь хүний гарт ч цөөнгүй хадлагдаж байна. Eriksson-ны авсан гэрэл зургийн илэрхийлж байгаа утга санааг тодорхойлохын тулд тухайн газарт нь очиж холбогдох хүмүүсийг сурвалжлан бичиг тэмдэглэлийг нь гаргуулан байж энэхүү илтгэлдээ 1913-1939 он хүртэлх монголын нийгмийн байдлыг задлан шинжлэхийг зорив.

Эцэст нь хэлэхэд, Шведийн шашин дэлгэрүүлэгчийн нүдэнд, элдэв өвчинд хүнд нэрвэгдсэн, мухар сүсэгт гүн автсан, ядуу буурай ард түмэнтэй, хулгай дээрэм дүүрсэн үймээн самуунтай монголын нийгэм үзэгдсэн байгаа гэж хэлж болно.

МОНГОЛ ДАХЬ ХРИСТИТГЭЛ: ТҮҮХ БА ОДООГИЙН БАЙДАЛ

Такизава КАЦҮХИКО
Дэд професор, Нагасаки Их Сургууль

Түлхүүр үг: Социологи, Шашин, Христитгэл, Монгол

1990 онд социализмын систем унаад Монгол Улсад шашны эрх чөлөөт байдал бий болсноос хойш түүнээс өмнөх үед харагдаагүй янз бүрийн шашны үзэгдэл гарч ирэв. Түүний нэг нь Христийн Евангелийн урсгалын сүм ба чуулганууд бий болоод өсөж ирсэн явдал юм. Тэд яг одоогийн байдлаар багцаалбал 80-90 мянган итгэгчтэй, 500 орчим сүм чуулгануудтай болсон байна. Тооны хувьд бол цөөнхөд орох боловч Монголын нийгэмд олон талын нөлөө үзүүлж байна. Гэхдээ түүний тухай нарийвчлан судалсан судалгаа нэг их байсангүй.

Энэ илтгэлтийн зорилго бол Монгол дахь Христитгэл (Christianity)-ийн түүх ба одоогийн байдлын тухай хээрийн судалгаанаас эхлээд янз бүрийн материалуудыг ашиглан судалж ирсэн миний судалгааны гол үр дүнг танилцуулж, түүний утга учрын талаар задалж илэрхийлэхэд оршино. Ялангуяа, зөвхөн Христитгэлийг үзэхээс биш социализмаас хойших үеийн Христитгэлийн өсөлт гэдэг энэ үзэгдлийг нь ХХ зууны ба одоогийн Монголын нийгэм, соёл, шашин гэх зэргийн динамизмыг туслах болгон ойлгоод задлан тайлбарлах болно.

Бас ийм утгаараа, Монгол дахь Христийн шашны номлолын түүх, Буддын шашны одоогийн дэлхий даяаршлалын байдал гэх мэт өөр цаг үе эсвэл бусад шашны байдлыг харьцуулан үзэх санаатай юм.

URBANIZATION ON THE TERRITORIES OF THE MONGOLIAN WORLD: STATE AND TENDENCIES OF DEVELOPMENT

BADARAEV Damdin

*Institute for Mongolian, Buddhist and Tibetan Studies
of the Siberian Branch of Russian Academy of sciences*

Keywords: Urbanization, Mongolian world, nomadism, migration

Nomadism in the process of evolutionary development has formed a stable nomadic culture with specific features, capable of maintaining its properties in the modernization of societies of the Mongolian world. With regard to the transitional society, the most pronounced is internal migration from rural areas to cities and large populated areas, with more accessible socio-cultural, educational and medical services.

The processes of urbanization and rural-urban migration in Mongolia and Buryatia have become one of the most significant signs of a change in the social composition of the rural and urban population. Unregulated mass rural-urban migration has a negative impact on the basics of traditional nomadic farming and entails a whole range of demographic, economic, social, and ecological consequences for both the dispenser and the receiving party. In this connection, the social problems of the transition economy are being actualized - unemployment, poverty, overpopulation of urban areas, mass unauthorized seizure of land and the construction of illegal housing in the suburbs, and a shortage of infrastructure facilities.

The decrease in the number of young people in rural areas and the migration of families to cities leads to an imbalance of productive forces in the agro-industrial sector.

Migration is one of the main channels of adaptation of the population to modern processes of globalization and modernization.

The cultural-civilizational feature in the process of urbanization is the ruralization of urban space, which turns the cities of the Mongolian world into a mixed city and village space, especially in the suburbs, whose inhabitants mostly come from rural areas.

The processes of migration and urbanization in modern Mongolian society demonstrate a high territorial mobility of the population. The main causes and factors of migration flows are due to traditional lifestyles and modern market, economic and demographic processes, which are significantly accelerated by globalization. The capitals of the Mongolian world gain an unprecedented image. In the future, only an increase in urbanization processes is expected.

МОНГОЛ УЛСЫН ИХ ДЭЭД СУРГУУЛИЙН УДИРДЛАГЫН СИСТЕМ

Ж.ЖАРГАЛМАА

*Японы JSPS байгууллагын Тусгай Судлаач,
Киото их сургууль*

Түлхүүр үг: Харьцуулсан боловсрол, дээд боловсрол, их дээд сургуулийн удирдлагын систем, удирдах зөвлөл

1924 онд Монгол улс нэг намын удирдлагын доор улс төр, эдийн засгийн менежментийг хөгжүүлэх социалист орон байсан боловч, 1990 онд ардчилалд шилжиж улмаар анхны чөлөөт ардчилсан сонгуулиар байгуулсан Ардын Их Хурлаар 1992 оны нэгдүгээр сарын 13-нд ардчилсан шинэ Үндсэн хуулийг баталсан нь үндсэн хуульд ардчилсан улс болохын баталгаа болсон юм. Энэхүү үндсэн хуулиар иргэдийн эрх тэгш эвлэлдэн нэгдэх, үзэл бодлоо илэрхийлэх эрх, эрх чөлөөг олгосон нь ардчиллын тухай ойлголтыг аливаа шийдвэр гаргахад олон хүний тэгш оролцоог хангах ёстой гэдэгт санал нэгдэж байв. Үүнийг дагаад Боловсролын салбарт бас томоохон өөрчлөлт оров. 1995 оны Боловсролын тухай хуульд боловсролын байгууллага ялангуяа дээд боловсролын байгууллагад эрх барих дээд байгууллага болох удирдах зөвлөл болон эрдмийн зөвлөл, захиргааны зөвлөл зэрэг институтууд шинээр байгуулагдахаар хуульчлагдав. Сургуулийн эрх барих дээд байгууллага болох удирдах зөвлөлийн (үүсгэн байгуулагч, оюутнууд, багш нар, эцэг эх, төгсөгчдийн төлөөлөлөөс бүрдэнэ) 51-60 хувь нь үүсгэн байгуулагчийн төлөөлөгч (улсын их сургуульд төрийн төлөөлөл дийлэнхи хувийг эзэлнэ) эзлэхээр шийдсэн юм. Яагаад үүсгэн байгуулагчийн (улсын их дээд сургуульд бол төрийн төлөөлөгчийн) эрх давамгайлсан систем бий болсон бэ? Ардчиллын олон хүний тэгш оролцоог хангах ёстой гэсэн ойлголттой зөрчилдөж байна. Энэ асуудлын хүрээнд Монгол дахь ардчилал, их сургуулийн талаарх ойлголт тэдгээртэй холбогдох матеариалыг судалж, их сургуулийн холбогдох хүмүүсээс авсан ярилцлагыг оруулан дүгнэлт хийж, 1990-ээд оны эхний хагас дахь Монгол улсын ардчиллын үзэл баримтлал болон их сургуулийн удирдлага, менежментийн системийн хоорондох зөрүү яагаад гарсан талаар Монгол улстай адилхан улс төрийн, эдийн засгийн тогтолцоо нь аль аль нь эсвэл аль нэгэн нь өөрчлөгдсөн улс орнуудтай харьцуулан улсын их дээд сургуулийн үзэл баримтлалын ялгааг тодруулах болно.

**“OTOR-IZATION” OF PASTORAL MIGRATION:
AN OVERVIEW OF CHANGING PASTORALISM IN MONGOLIA
DURING THE LATE 20TH CENTURY AND THE EARLY 21ST CENTURY**

KAMIMURA, Akira

Tokyo University of Foreign Studies

This paper overviews the changes in pastoralism in Mongolia during the late twentieth century and early twenty-first century, drawing on data from ethnographic research and formal surveys carried out since 1993 in the Huhbelchir sub-district (*bag*), Duut district (*soum*), Hovd prefecture (*aimag*) in the western part of Mongolia. It aims to show how Mongolian herders have been adapting to the transition to the market economy and the global economy (namely, the privatization process which started in the early 1990's or the last decade of the twentieth century), focusing in particular on the changes in their migration pattern.

Whereas in the early 1990's the disassembly of cooperatives increased the number of livestock-breeding households, the increase in the number of livestock due to a relatively positive weather condition with the number of pastoral households, stabilizing from 2003 to 2008, entailed in turn an increase of those lone households who had too large herds to integrate them with another household's since the maximum size of herds to pasture without difficulty is supposed to be 1200 - 1500. The lone households with large herds needed more mobility, as well as a car for that high mobility. They chose Russian 4WD military jeeps, not the Korean-made medium-sized trucks generally chosen in other areas in Mongolia for their low fuel consumption, as they were not suitable to that mountainous area. Quite a few households with Russian jeeps downsized their ger by cutting the *uni* (wooden parts of the roof) and shortening the *hana* (wooden parts of the wall) so as to fit it into their cars to reduce transport costs. Most had a *tom* (big) ger in the district or prefecture center, calling their downsized gers *jijig* (small) gers or *malyu* (livestock's) gers, such as small gers for *otors*. An *otor* is an opportunistic move, usually carried out by part of the household driving a specific part of the livestock, with a simple dwelling—a tent or parts of a ger—for the specific purpose of livestock breeding, all of which entail high mobility. Some Mongolian areas have also seen the emergence of several temporary single-person pastoral households, with just the husband engaging in livestock breeding in the countryside by himself, while the wife and children live in the center. One main reason for people's preferring to live in the center is the opportunity for better education for children due to the unstable and unclear future of pastoralism.

Murphy (2011:1) defines “*otor*” as “a non-customary migration strategy whereby a household interrupts their normal four season campsite rotation to either opportunistically exploit pasture or evade hazardous conditions”. However, for current Mongolian pastoralism this demarcation between “*otor*” and “a customary migration” or “a normal four season campsite rotation” has become rather meaningless. Most of the pastoral migrations appear to be “*otor*”, or have some considerable characteristics of it. We could term this phenomenon as “*otor-ization*” of pastoral migration.

LOOKING BACK ON MPR: THE MONGOLIAN ATTITUDE TOWARD THEIR COUNTRY AND LIFE UNDER SOCIALISM

Kunio MINATO
Kochi University, Japan

This study analyzes how the Mongolians recollect their country and life under socialism by using the first round of the Life in Transition Survey. The survey was conducted in 2006 and asked respondents, at the point of survey than those in 1989, whether they thought economy, politics, and living condition got better, as well as whether there is less corruption. In this study the result in Mongolia will be compared with other former socialist countries, and analyzed relations with other factor. As the result of change in living condition was addressed in the former study (Minato, K., 2011, “Who Feels Left Out? Perceptions of Mongolians About Changes in Living Conditions During the Transition,” *Mongol-Kenkyu (Journal of Mongolian Studies)*, 26: 34-45), this study expand the scope and address Mongolian public attitude not only toward personal life but also on country as a whole. By doing so, this study aims to offer some descriptions on what was socialism in 20th century for the Mongolians, and what factors are behind recollection of the era by them.

